Засаг даргын ажлын албыг бэхжүүлэх, бүх шатны Хурлын ажль сайжруулахад төсөв, санхүүгийн нөөц хомс байгаа явдал ч бэрхшээ учруулж байна. Нутгийн захиргааны байгууллагын дийлэнх н санхүүгийн талаар төвөөс үлэмж хамааралтай хэвээр байна. Нутгий захиргааны зарим байгууллага өөрийгөө санхүүжүүлэх санаачла гарган, цалин хөлс, эрчим хүч, дулааны зардлыг өөрсдөө хариуца байна. Гэвч орон нутгийн өөрийгөө санхүүжүүлэх ажлын цар хүр нь зохих түвшингийн үйлчилгээ үзүүлэх, орон нутгаа хөгжүүл санаачлагыг өрнүүлэхэд хүрэлцэхгүй байна. Нутгийн захиргаан байгууллагын удирдлагын чадавхийг сайжруулахад хөрөнгийн зох эх үүсвэр шаардлагатай юм. Үүний тулд орон нутгийн төсвий орлогын баазыг бэхжүүлэх, орон нутгийн татвар бий болгох н чухал юм. Энэ үндсэн дээр төвлөрсөн төсвөөс орон нутагт дахи хуваарилах хэмжээг аажмаар багасгах шаардлагатай байн Ингэснээр засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн хэмжээнд иргэд үзүүлэх хамгийн наад захын үйлчилгээний үндсэний стандарть тогтоон мөрдүүлэх, орон нутгийн хөгжлийн ерөнхий ба тэргүүл чиглэл, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийг боловсруулан хэрэгжүүл боломж бүрдүүлнэ.

Төвлөрлийг сааруулах нь эрх мэдлийг хуваах гэсэн утгаар зөвхөн ажил, үүргийг шилжүүлэхээс гадна бүх шатны Хурлы санаачлагыг өрнүүлэх, эрх мэдлийг нь өргөтгөхөд чиглэгдэнэ. Үүни зэрэгцээ санхүүгийн болон удирдлагын чадавхийг дээшлүүл асуудлыг давхар шийдэх шаардлагатай байна.

**1.2.5. Өмч хувьчлалын хүчин зүйлийн талаар**

Өмч хувьчлах ажлын үр дүнд нийт эдийн засгт бүтций томоохон өөрчлөлт гарав. Улсын хэмжээгээр 900 гаруй том, 30 шахам жижиг үйлдвэр, аж ахуйн газар хувьчлагдав.

Одоогийн байдлаар улсын 203 үйлдвэр, аж ахуйн газар төри мэдэлд үлдээд байна. Тэрчлэн хувьцаат 259 компанийн ни хувьцааны тодорхой хэсгийг төр эзэмшиж байгаагийн дот тэдгээрийн 197-д нь төрийн өмч давамгайлж байна. Гэтэл эдгэ компанид төрийн өмчийг төлөөлөх, шилжилтийн үед тэднийг з зээлийн эдийн засагт нийцүүлэн удирдан зохион байгуул зохицуулах, өмч хувьчлалын хоёр дахь үе шатанд идэвхт оролцуулах, шашлын үйл ажиллагааны талаар гээз байгуул

биелэлтэд нь хяналт тавих удирдлагын шинэ тогтолцоо үгүйлэгдэж байна.

Өмч хувьчлалын хоёр дахь үе шатанд бэлэн мөнгөөр хувьчлах механизм үйлчилж, хяналтын багц хувьцааг чадавхи бүхий хөрөнгө оруулагчдад худалдсанаар эрхийн бичгээр хувьчлал хийх явцад компанийн удирдлага, төлөөллийг боловсронгуй болгох талаар үүрэмтлагдсан асуудлыг шийдвэрлэх нөхцөл бүрдэнэ.

Хувьчлагдсан үйлдвэр, аж ахуйн газар, компанийн удирдлага сул байгаагийн нэг гол шалтгаан нь цөөн тооны хувьцаа эзэмшдэг бөгөөд мянган жижиг хөрөнгө оруулагчид орон даяар таран хуурьшиж байгаатай холбоотой учраас хувьцаа эзэмшигчийн хурлыг хийхэд бэрхшээл учирч, захирлуудын зөвлөлийг сонгоход хүндрэлтэй байна. Төрийн хяналтаас гарсан эдгээр үйлдвэр, аж ахуйн газруудад компанийн жинхэнэ эздийн зүгээс тавих хяналт сулгадсанаас болж үйлдвэрийн удирдлага, эсхүл ажилчдын хязгааргүй эрх мэдэл тогтооход хүргээд байна. Ийм нөхцөлд хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхлыг ч, зайлшгүй шаардлагатай бүтцийн өөрчлөлт, шинэчлэлийг ч ихэнх тохиолдолд үл ойшоох хандлага гарч байна.

Үнэт цаасны хоёр дахь зах зээл нь хувьцаат компанийн хувьцааг эзэн болж чадах цөөн хүний гарт төвлөрүүлэхэд тус дөхөм болох бөгөөд энэхүү үйл явцын үр дүнг урьдчилан таамаглах нь хэцүү төдийгүй маргаантай асуудал юм. Гэхдээ энэ үйл явцын үр дүнд үйлдвэр, аж ахуйн газрын төрийн өмчид үлдсэн хэсгийг бэлэн мөнгөөр арилжаалах, шинээр хөрөнгө оруулалт хийх, өр, зээлийн асуудлыг шийдэх, экспортод чиглэсэн үйлдвэрлэл, үйлчилгээ бий болгох нөхцөл, тэрчлэн хувьчлагдсан үйлдвэр, аж ахуйн газарт зах зээлд зохицон үйл ажиллагаагаа явуулах боломж тус тус бүрдэнэ. Гэвч эдгээр механизмыг бүрэн ажиллуулахын тулд үйлдвэр, аж ахуйн газрын удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатай. Энэ тогтолцоо нь төр, засгаас өөрийн чиг үүргийг зах зээлийн эдийн засгийн нөхцөлд зохих ёсоор гүйцэтгэдэг болох, үүнчлэн бие даан амьдрах чадвартай хувийн хэвшил хөгжин бэхжихэд ихээхэн хувь нэмэр оруулах болно.

**1.3.** Төрийн захиргаа, төрийн албаны өөрчлөлт, шинэчлэл хийх зайлшгүй хэрэгцээ нь төрийн албаны үйл ажиллагаанд нөлөөлж байгаа шилжилтийн үеийн үйл явцын; макро эдийн засаг, бодлогын; төсөв, санхүүгийн; удирдлагын чадавхийн асуудалтай холбогдсон доор дурдсан 4 хүчин зүйл буюу "шаардлагын дөрвөн эг"-ээс урган гарч байна:




### 1.3.1. Шилжилтийн үеийн үйл явцын асуудалтай холбогдсон шаардлагын талаар

Энэ шаардлага нь шилжилтийн үйл явцыг даван туулах таатай орчныг бүрдүүлэхэд чиглэсэн өөрчлөлт, шинэчлэл хийх зайлшгүй хэрэгцээг тодорхойлж байна.

Зах зээлийн эдийн засгийн мэдлэг хангалттүй, ардчилал, зах зээлийн эдийн засгийн харилцааны үеийн Засгийн газрын үүргийн талаархи ойлголт цэгцрээгүй байна. Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын удирдах, гүйцэтгэх албан тушаал эрхлэж байгаа төрийн албан хаагчийн зарим хэсэг нь шинэ нөхцөл байдалд Засгийн газраас ард түмэндээ үйлчлэх төрийн үйлчилгээний чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд чухам ямар арга барилаар яаж ажиллах, ард иргэд өөрсдөөс нь чухам юу хүсэн хүлээж байгааг тэр бүр ухамсарлан ойлгохгүй байна. Иймээс тэдний явуулж байгаа үйл ажиллагаа нь төрийн тодорхой зорилт, чиг үүргийг шийдвэрлэхэд бүрэн чиглэж чадахгүй, давхардсан, хүч, нөөцийг тарамдуулсан шинжтэй байна.

Төрийн захиргааны алба, албан хаагчид нь гагцхүү төрийн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа явуулах бөгөөд үүний эцсийн үр дүн нь түүний биелэлтээр хэмжигдэх ёстой. Гэвч төрийн захиргааны байгууллага шинэ нөхцөлд өмнөө дэвшигдэж

байгаа төрийн зорилт, чиг үүргийг бүрэн хэмжээгээр тэр бүр тодорхойлж чадаагүй байгаагаас үйл ажиллагааных нь үр дүнг үнэлж дүгнэхэд хүндрэл учирч байна.

Шилжилтийн үйл явцыг удаашруулж байгаа энэ хүчийг сааруулж, уг үйл явцыг тууштай урагшлуулах таатай нөхцлийг бүрдүүлэхэд чиглэсэн өөрчлөлт, шинэчлэл хийх нь гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын нэг тулгамдсан асуудал болж байна.

**1.3.2. Макро эдийн засаг, нийгмийн асуудалтай холбогдсон шаардлагын талаар**

Энэ шаардлага нь нийгмийн хөгжлийг дэмжсэн макро түвшингийн эдийн засаг, нийгмийн орчинг бий болгоход чиглэсэн өөрчлөлт, шинэчлэл хийх зайлшгүй хэрэгцээг тодорхойлж байна.

Макро эдийн засгийн түвшинд мөнгө санхүүгийн хувьд харьцангуй тогтвортой байдал бий болж, эдийн засгийн уналт буурал зогсож, өсөлт хөгжлийн зарим ааштай эхлэл бий болж байна. Гэвч эдийн засгийн зохицуулалт, тогтвортой хөгжлийн нөхцөл бүрдээгүй, ажилгүйдэл, ядуурлын хүчин зүйл үйлчилсээр байна. Нийгмийн үйлчилгээний хүрээ өсч байгаа боловч түүний чанар хангалттүй хэвээр байна. Энэ байдалд хөрөнгө оруулалтын дутагдал, гадаад, дотоод худалдааны үйл ажиллагааны доголдол улам хэрмээс болж байна. Өөрөөр хэлбэл, хөгжлийн шаардлагыг хангаж чадахуйц макро түвшингийн эдийн засаг, нийгмийн таатай орчин төлөвшөөгүй байгаа нь гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын үйл ажиллагаанд шахалт үзүүлсээр байна.

**1.3.3. Төсөв, санхүүгийн асуудалтай холбогдсон шаардлагын талаар**

Энэ шаардлага нь төсвийн алдагдал, Засгийн газрын зардлыг бууруулах, төлбөрийн чадварыг дээшлүүлэх замаар төсөв, санхүүгийн таатай орчин бий болгоход чиглэсэн өөрчлөлт, шинэчлэл хийх зайлшгүй хэрэгцээг тодорхойлж байна.

Одоогийн байдлаар төсөв, санхүүгийн асуудалтай холбогдсон шаардлага нь Засгийн газарт ихээхэн бэрхшээл учруулж байна. Ірэгдэд зөвхөн хамгийн наад захын үйлчилгээ үзүүлж байгаа хэдий олович улсын төсвийн алдагдал, урсгал зардал их байсан, одоо ч өдийлөн буурахгүй байна. Гадаад өрийг дотоодын нийт үтээгдэхүүнтэй харьцуулсан харьцаа өсч байна (**Энэ харьцааг отоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл, төсвийн орлогыг өсгөж, ардлыг багасгахгүйгээр ойрын хугацаанд бууруулах боломж бага айна**).

Орлогын шинэ эх үүсвэрийг ойрын хугацаанд бүрдүүлэх боломж язгаарлагдмал байна. Ажиллагчдын цалин хөлс харьцангуй бага өгөөд урсгал төсөв нь яам, тусгай газар чиг үүргээ бүрэн

хэмжээгээр хэрэгжүүлэхэд хүрэлцээтэй биш байна. Дээр дурдсан асуудлыг нааштай шийдвэрлэх үүднээс хөтөлбөрийнхөө биелэлт, өртөг, зардал, үйл ажиллагаагаа хатуу хянаж байхыг олон улсын санхүүгийн байгууллагууд Засгийн газарт зөвлөдөг. Энэ зөвлөмжийг биелүүлэхгүй тохиолдолд хандивлагч орон, олон улсын байгууллагатай ээл, тусламж авах талаар хэлэлцэн тохиролцоход хүндрэл гарч болзошгүй юм.

### 1.3.4. Удирдлагын чадавхийн асуудалтай холбогдсон шаардлагын талаар

Энэ шаардлага нь бага зардлаар их үр дүнд хүрэх удирдлагын чадавхи бүхий төрийн захиргааны албыг бүрдүүлэхэд чиглэсэн өөрчлөлт, шинэчлэл хийх зайлшгүй хэрэгцээг тодорхойлж байна.

Хүний нөөцийн удирдлагын хүчин зүйлийг дутуу ашиглаж байна. Төвлөрсөн удирдлага, төлөвлөлт, хяналтанд тохирч байсан удирдлагын арга барил, ур чадвар нь шилжилтийн болон ардчилал, зах зээлийн тогтолцоонд тохирохгүй болсон бөгөөд үүнийг өөрчлөх ажил эхлэлийн шатандаа байна.

Удирдлага, нягтлан бодох бүртгэл, хөндлөнгийн хяналтын шинэ тогтолцоог бий болгох эхлэл тавигдаж байна. Удирдах, гүйцэтгэх ажилтнуудын ур чадвар зах зээлийн эдийн засгийн шаардлагын хэмжээнд хүрээгүй байна. Бага зардлаар бүтээлтэй ажиллах чадварыг сайжруулахад чиглэсэн удирдлагын чадавхи бий болгох замаар төрийн үйлчилгээний чанарыг эрс дээшлүүлэх нь чухал байна.

Дээр дурдсан 4 төрлийн шаардлага нь Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэл хийх зайлшгүй хэрэгцээг тодорхойлж байна.

## Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛИЙН ӨӨРЧЛӨЛТ, ШИНЭЧЛЭЛИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО

**2.1.** Засгийн газрын үйл ажиллагааны үндсэн зарчим нь Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан ёсоор ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх явдал мөн.

Засгийн газар нь үйл ажиллагааныхаа үндсэн зарчимд тулгуурлан төрийн гүйцэтгэх дээд байгууллагынхаа үүрэг, чиг үүрэг, бүрэн эрхийг дор дурдсан хуулийн хүрээнд хэрэгжүүлнэ:

- **Үндсэн хууль**
- **Засгийн газрын тухай хууль**

- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Бусад хууль

Ардчилсан нийгэм дэх зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих шилжилтийн нөхцөлд Засгийн газар нь удирдлагын болон ндэсний тэргүүлэн манлайлах чадавхи бий болгох зорилгоо эрэгжүүлэхийн тулд бодлого ба төлөвлөлт, тохируулга ба үйлчилгээ үүлэх зэрэг дээд түвшний чиг үүргийг Монголын нийгмийн ашиг энирхлын үүднээс авч хэрэгжүүлнэ.

**2.2.** Монгол Улсын Үндэсний хөгжлийн үзэл баримтлал нь илжилтийн үеийг даван туулж, үндэсний эдийн засгийг сэргээн огтворжуулах, улмаар тогтвортой өсөлтийг хангах, өөрийгөө этгэдэг бат суурьтай эдийн засгийг бий болгоход чиглэж байна. үүнийг гурван үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

- **Нэгдүгээр үе шатанд буюу 2000 он хүртэлх хугацаанд эдийн засгийг тогтворжуулж, пааццын хөгжлийн үндэс суурийг тавина. Энэ шатанд төрийн захиргааны өөрчлөлт, шинэчлэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, стратегийн чанартай бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэх, хөрөнгө оруулалтын хэрэгцээг хангах зорилгоор дотоодын хуримтлалыг нэмэгдүүлэх, ядуурал, ажилгүйдлийг багасгах, нийгмийн дэд бүтцийн үйлчилгээний түвшинг дээшлүүлнэ.**
- **Хоёрдугаар үе шатанд буюу 2000-аас 2010-аад он хүртэл хугацаанд эдийн засгийг сэргээн, түүний тогтвортой өсөлтийг хангах, өөрийгөө тэтгэдэг эдийн засаг бий болгох үндэс суурийг тавих зорилтыг хэрэгжүүлнэ. Эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийг эрчимжүүлж, юуны өмнө экспортын чиглэлийг хүчтэй болгон, эдийн засгийн өсөлтийн хурдыг тогтвортой нэмэгдүүлж, эдийн засагт аялал жуулчлалын цогцолборын эзлэх байр суурийг улам нэмэгдүүлнэ.**
- **Гуравдахь үе шатанд буюу 2010 оноос цаашхи хугацаанд үндэсний болон дэлхийн өндөр технологид үндэслэн хүрээлэн буй орчинд аюулгүй, экспортын баримжаатай зах зээлийн оновчтой бүтцийг бий болгон, Азия, ялангуяа Зүүн хойд Азид Монгол Улс өөрийн байр суурийг олж авна. Монгол Улс эрчим хүч, түлш, хүнсний гол нэрийн зарим бүтээгдэхүүний өөрийн хэрэгцээг бүрэн хангана. Мал аж ахуй, эрдсийн гаралтай түүхий эдийг гүнзгий боловсруулан экспортод гаргах үйлдвэрийн газрууд, үйлчилгээний салбар, аялал жуулчлалын цогцолборыг эрчимтэй хөгжүүлсэн харьцангуй бие даасан, үр ашигтай бүтэц бүхий эдийн засагтай болно.**

Үндэсний хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд шаардлагатай үндэсний тэргүүлэн манлайлах чадавхи бий болгох хэмжээнд хүртэл Засгийн газрын үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөн шинэчлэх нь уг үзэл баримтлалыг амжилттай хэрэгжүүлэх уггвар нөхцөл болно.

**2.3.** Засгийн газар нь үйл ажиллагааныхаа хөтөлбөрийн төсөл бүрэн эрхийнхээ хугацаанд баримтлах Засгийн газрын тэргүүлэх чиглэлийг тодорхойлох бөгөөд уг хөтөлбөрийн төслийг холбогдох хуульд заасан журмын дагуу батлуулан, биелэлтийг нь зохион байгуулна.

Засгийн газрын өнөөгийн тэргүүлэх чиглэл нь дор дурдсан үндсэн асуудлын хүрээг хамаарч байгаа юм:

- **Макро түвшинд эдийн засгийг тогтворжуулах**
- **Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах**
- **Удирдлагын чадавхийг сайжруулах (нягтлан бодох бүртгэл хөндлөнгийн хяналт, санхүүгийн болон төрийн өмчийн удирдлагыг оролцуулан)**
- **Төрийн захиргаа, төрийн албыг өөрчлөн шинэчлэх (төвлөрлийг сааруулах, нутгийн захиргааг бэхжүүлэхийг оролцуулан)**
- **Боловсролын салбарыг хөгжүүлэх (шинжлэх ухааныг оролцуулан)**
- **Бэлэн мөнгөөр хийх хувьчлал, үнэт цаасны хоёрдогч зах зээлий хамарсан өмч хувьчлал**
- **Эрх зүйн тогтолцоог хөгжүүлэн, түүний биелэлтийг хангах**
- **Дэд бүтцийг хөгжүүлэх (төмөр зам, агаарын тээвэр, эрчим хүч харилцаа холбоо г.м)**
- **Үндэсний үйлдвэрлэлийг сэргээх**

Засгийн газрын тэргүүлэх чиглэл нь бодлогын баримт бичгийг боловсруулах буюу түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэл болно.

**2.4.** Үндсэн хуульд тунхагласан эх орондоо хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм байгуулах эрхэм зорилго, түүнийг хэрэгжүүлэхэд чиглэсэн Үндэсний хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан ойрын 10-15 жилийн хугацаанд баримтлах Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны стратегийн эрхэм зорилгыг дор дурдсан байдлаар тодорхойлж байна:

**-ЭРХЭМ ЗОРИЛГО-**

Ардчилсан нийгэм дэх зах зээлийн
эдийн засгийн харилцааны шаардлагад
Засгийн газрын үйл ажиллагааг нийцүүлж,
бие даан амьдрах чадвартай хувийн
хэвшлийг бий болгон бэхжүүлэхэд туслах

**2.5.** Дээр дурдсан эрхэм зорилгод хүрэхийн тулд ойрын таван жилийн хугацаанд хэрэгжүүлэх Засгийн газрын үйл ажиллагааны стратегийн зорилтыг доор дурдсан байдлаар томъёолж байна:

**2.5.1.** Засгийн газрын тэргүүлэн манлайлах үүргийг дээшлүүлж, үндсэн үйл ажиллагааг нь сайжруулах: **Засгийн газрын одоогийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ болон дэвшүүлж байгаа эрхэм зорилгоос Засгийн газрын үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоог зорвитой өөрчлөн шинэчлэх шаардлага урган гарч байна. Үйл ажиллагаанысаа бүтцийн ерөнхий тогтолцоонд тохирсон Засгийн газрын үүрэг нь тэргүүлэн манлайлах; төлөвлөлт, бодлогын үндсэн чиглэлээр хангах; үр бүтээлтэй хувийн хэвшлийг дэмжиж, хөгжих нөхцлийг нь бүрдүүлэх; Монгол Улсын иргэдийн аюулгүй байдал, эрүүл мэнд, соёл, боловсрол, сайн сайхан аж амьдралыг баталгаажуулах явдал мөн. Засгийн газрын үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоонд тохирсон Засгийн газрын бүтэц нь цомхон, үр нөлөөтэй, чадварлаг бөгөөд удирдлагын цөм болсон байх ёстой.**

**2.5.2.** Засгийн газрын гүйцэтгэх удирдлагын чадварыг бэхжүүлэх: **Энэ зорилт нь Засгийн газрын гүйцэтгэх удирдлагын чадварыг бэхжүүлэхэд оршино. Үүнд Засгийн газрын танхим болон Ерөнхий сайдын удирдлагын зөвлөх Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын удирдлагын чадварыг дээшлүүлэх асуудал хамаарна. Төрийн гүйцэтгэх зээд байгууллагын түвшинд оновчтой шийдвэр гаргах явдлыг баталгаажуулах, үүний дотор Засгийн газар болон нутгийн захиргааны байгууллагын хооронд үр нөлөөтэй зохицуулалт хийх, хариуцлагыг хуваарилах, ажлаа тайлагнах тогтолцоо бий болгоход чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.**

**2.5.3.** Нутгийн өөрөө удирдах ёс, нутгийн захиргааг бэхжүүлэх:

**Нутгийн өөрөө удирдах ёс нь ардчилсан нийгмийн гол үндэс юм. Засгийн газраас үзүүлэх үйлчилгээний дийлэнх хэсэг (эрүүл мэнд, соёл, боловсрол, нийгмийн бусад үйлчилгээ) төвлөрдөг орон нутгийн**

түвшинд үр нөлөө бүхий удирдлагын чадавхи бүрдсэн байх ёстой. Үүни тулд бүх шатны Засаг даргын ажлын албыг бэхжүүлэх шаардлагата! Төрлөн төсөв, санхүү, удирдлагын зохистой тогтолцоо бий болгох ардчиллын үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, төрийн гүйцэтгэ дээд байгууллагын үйл ажиллагаатай ажил нь давхардахгүй бай нөхцлийг бүрдүүлнэ.

**2.5.4.** Хувийн хэвшил хөгжих таатай орчин бий болгох: **Засгий газрын үүргийг бүх түвшинд шинэчлэн тогтоохдоо Засгийн газар н Монгол Улсын нэг гол үйлдвэрлэн бүтээгч болохынх нь хувьд хувий хэвшилд дэмжлэг үзүүлэгч, хөгжих нөхцлийг бүрдүүлэгч болохоо то томруун харуулахад онцгой анхаарах болно.** Энэхүү стратегий зорилтод өмч хувьчлалын хоёрдахь үе шат болох бэлэн мөнгөни хувьчлалыг хэрэгжүүлэх, хувьчлагдсан үйлдвэр, аж ахуйн газры бүтцийг өөрчлөх, жижиг, дунд үйлдвэрийг дэмжих асуудал мө хамаарна. **Жижиг, дунд үйлдвэрийг байгуулах, хөгжүүлэх, үйлдвэрий газрынхаа бүтцийг өөрчлөн шинэчлэх ажлыг хувийн хэвшил өөрөө хий бөгөөд үүнд Засгийн газрын дэмжлэгтэйгээр Засгийн газрын бү байгууллагууд тус дөхөм үзүүлнэ.**

**2.5.5.** Төрийн захиргааны өөрчлөлт, шинэчлэлийн үр дагаврь удирдаж зохицуулах: **Стратегийн дээр дурдсан дөрвөн зорилтс хүрэхэд төдийлөн хялбар биш бөгөөд Засгийн газрын үйл ажиллагаан болон нийгмийн янз бүрийн давхарга, хэсгүүдэд түр зуурын зари хүндрэл, бэрхшээл учирч болох юм. Өөрчлөлт, шинэчлэлийн эдгэз сөрөг үр дагаврыг арилгах зорилгоор ажиллах хүчнийг зохицуулах байгууллага, хамт олныг хөгжүүлэхэд хөтөлбөр боловсруула хэрэгжүүлэх болон хөдөлмөрийн харилцааг зохицуулахад чиглэсэ тусгай арга хэмжээ авна.**

**2.6.** Засгийн газрын үйл ажиллагааны стратегийн дээр дурдса зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн Засгийн газрын үйл ажиллагаан гол зорилтыг дор дурдсан байдлаар дэвшүүлж байна:

- **"Засгийн газрын тэргүүлэн манлайлах үүргийг дэвшүүлж, үндсэ үйл ажиллагааг нь сайжруулах" гэсэн Засгийн газрын үй ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд:**

2.6.1. Засгийн газрын стратегийн бодлого, төлөвлөлтийн чад варыг дээшлүүлэх

2.6.2. Хөгжлийг төлөвлөх, эдийн засгийг удирдах Засгийн газ рын чадварыг дээшлүүлэх

2.6.3. Засгийн газрын мэдлийн салбар, салбар бүрт байх чиглэ лийн яамдын тоог оновчтой тодорхойлох

2.6.4. Чиглэлийн яамдыг бодлого, төлөвлөлтийн байгууллага байхаар бүтцийг нь өөрчлөх

2.6.5. Засгийн газрын тохируулагч агентлагуудын оновчтой тогтолцоог бүрдүүлэх
2.6.6. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны шинэ шалгуур бий болгох
2.6.7. Улсын үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд Засгийн газраас оролцох оролцоог цэгцэлж, бодлого, хөрөнгө оруулалт, удирдлагын зорилгуудыг ялган зааглах

- "Засгийн газрын гүйцэтгэх удирдлагын чадавхийг бэхжүүлэх" **гэсэн Засгийн газрын үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд:**

2.6.8. Ерөнхий сайдын болон Танхимын үүргийг өндөржүүлэх
2.6.9. Ерөнхий сайдад болон Танхимд үзүүлэх удирдлагын дэмжлэгийг сайжруулах
2.6.10. Засгийн газрын санхүүгийн удирдлага, нягтлан бодох бүртгэл, хөндлөнгийн хяналтын чадварыг дээшлүүлэх
2.6.11. Засгийн газрын нийтлэг үйлчилгээний удирдлагыг нэгтгэн, үйлчилгээний хүрээг өргөтгөн зохион байгуулах

- "Нутгийн өөрөө удирдах ёс, нутгийн захиргааг бэхжүүлэх" **гэсэн Засгийн газрын үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд:**

2.6.12. Бүх шатны Хурлын чадварыг дээшлүүлж, чиг үүргээ үр нөлөөтэй хэрэгжүүлэх боломж бүрдүүлэх
2.6.13. Бүх шатны Засаг даргын ажлын албаны чадварыг дээшлүүлж, чиг үүргээ үр нөлөөтэй хэрэгжүүлэх боломж бүрдүүлэх
2.6.14. Орон нутгийн санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх
2.6.15. Засгийн газар, нутгийн захиргааны байгууллага хоорондын харилцааг бэхжүүлэх

- "Хувийн хэвшил хөгжих таатай орчин бий болгох" гэсэн Засгийн газрын үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд:

2.6.16. Өмч хувьчлалын үйл явцын хоёр дахь шат болох бэлэн мөнгөний хувьчлал хийх
2.6.17. Хувьчлагдсан томоохон үйлдвэр, аж ахуйн байгууллагын удирдлага, үйл ажиллагаа сайжруулах үүднээс тэдгээрийн бүтцийг өөрчлөн шинэчлэх
2.6.18. Засгийн газрын бус байгууллагаар төрийн үйлчилгээ үзүүлэх явдлыг өргөжүүлэх замаар бизнесийн хөгжлийг дэмжих

- "Төрийн захиргааны өөрчлөлт, шинэчлэлийн үр дагаврыг удирдаж зохицуулах" гэсэн Засгийн газрын үйл ажиллагааны стратегийн 5 дугаар зорилтын хүрээнд:

2.6.19. Өөрчлөлт, шинэчлэлийн сөрөг үр дагаврыг багасгах

2.6.20. Төрийн албанд ажиллах сонирхол, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг дээшлүүлэх

**2.7.** Засгийн газрын үйл ажиллагааны стратегийн загварыг дор дурдсан байдлаар тодорхойлж түүнд өөрчлөлт, шинэчлэлийн үйл ажиллагааны зорилтыг тусган үзүүлбэл:


ЭРХЭМ ЗОРИЛГО
Засгийн газрын үндсэний гэрүүлэн манлайлах үүргийг дээшлүүлж, үндсэн үйл ажиллагааг нь сайжруулах
СТРАТЕГИЙН ЗОРИЛТ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГОЛ ЗОРИЛТ
АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ
Засгийн газрын стратегийн бодлого, төлөвлөлтийн чадварыг дээшлүүлэх
Бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагаа явуулах
Засгийн газрын хөгжлийн төлөвлөлт, эдийн засгийн удирдлагын чадварыг дээшлүүлэх
Эдийн засгийн чиг үүргийг төвлөрүүлэх
Тусламжийн удирдлага, зохицуулалтыг бэхжүүлэх
Үндэсний эдийн засгийн бодлого, зохицуулалтыг боловсронгуй болгох
Засгийн газрын мэдлийн салбар, салбар бүрт байх чиглэлийн яамдын тоог оновчтой тогтоох
Засгийн газрын мэдлийн салбарыг тогтоох
Салбар тус бүрээр чиглэлийн яамыг тодорхойлох
Чиглэлийн яамдыг бодлого, төлөвлөлтийн байгууллага байхаар бүтцийг нь өөрчлөх
Чиглэлийн яамдыг бодлого, төлөвлөлтийн байгууллага болгон бүтцийг нь өөрчлөн шинэчлэх
Тохируулагч агентлагуудыг оновчтой тогтолцоог бүрдүүлэх
Тохируулагч агентлагуудыг тогтоох
Хэрэгжүүлэгч агентлаг, төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны шинэ шалгуурыг бий болгох
Хэрэгжүүлэгч агентлагуудыг тогтоох
Хэрэгжүүлэгч агентлаг болон төсөвт байгууллагын шалгуурыг тогтоох
УҮГ-ын үйл ажиллагаанд Засгийн газрын оролцоог шинэчлэж, бодлого, хөрөнгө оруулалт, удирдлагын зориулалт илгэн заагла
Төрийн өмчийн удирдлагыг бэхжүүлэх
Улс, хувийн хэвшлийн хоорондын харилцааны шинэ хэлбэрийг бий болгох


Ардчилсан нийгэм дэх зах зээлийн эдийн засгийн харилцааны шаардлагад Засгийн газрын үйл ажиллагааг нийцүүлж, амьдрах чадвартай хувийн хэвшлийг бий болгон бэхжүүлэхэд туслах
Засгийн газрын гүйцэтгэх удирдлагын чадавхийг бэхжүүлэх
Ерөнхий сайд, Танхимын үүргийг өндөржүүлэх
-Ерөнхий сайдын эрх, үүргийг өргөтгөх
-Танхимыг дэмжих тогтолцоог сайжруулах
-Танхимд асуудал оруулах, хэлэлцэх тогтолцоог боловсронгуй болгох
Ерөнхий сайд, Танхимд удирдлагын дэмжлэгийг сайжруулах
-Стратегийн удирдлага, төлөвлөлтийг нэвтрүүлэх
-ЗГ/нутгийн захиргааны байгууллагын хоорондын харилцааг бэхжүүлэх
-Хүний нөөцийн удирдлагыг сайжруулах
Засгийн газрын санхүүгийн удирдлага, хөндлөнгийн хяналтын чадварыг дээшлүүлэх
-Татвар төлөвлөх, шинжлэх ажлыг сайжруулах
-Төсөв, зардлын удирдлагын тогтолцоог бэхжүүлэх
-Хяналтын шинэ тогтолцоог бий болгох
-Ня-бо бүртгэл, хөндлөнгийн хяналт, зөвлөгөө өгөх үйлчилгээг бий болгох
Засгийн газрын нийтлэг үйлчилгээний удирдлагыг нэгтгэн зохион байгуулах
-Нийтлэг үйлчилгээний бодлого боловсруулах
-Нийтлэг үйлчилгээг турших
-Үл хөдлөх хөрөнгийн нийтлэг үйлчилгээ
-Мэдээллийн тогтолцооны нийтлэг үйлчилгээ
-Бэлтгэн нийлүүлэх, гэрээлэх нийтлэг үйлчилгээ

| | | |
|---|---|---|
| Нутгийн өөрөө удирдах ёс, нутгийн захиргааг бэхжүүлэх | Бүх шатны Хурлыг бэхжүүлэх | Бүх шатны Хурлыг бэхжүүлэх |
| | Засаг даргын ажлын албыг бэхжүүлэх | Засаг даргын ажлын албыг бэхжүүлэх |
| | Орон нутгийн санхүүжилтийг нэмэгдүүлэх | Нутгийн захиргааны санхүүгийн механизмыг бий болгох |
| | Засгийн газар, нутгийн захиргааны байгууллагын хоорондын харилцааг бэхжүүлэх | Нутгийн захиргааны байгууллага / ЗГ-ын харилцааг бэхжүүлэх |
| Хувийн хэвшил хөгжих таатай орчин бий болгох | Өмч хувьчлалын II үе шат болох бэлэн мөнгөний хувьчлал хийх | Бэлэн мөнгөний хувьчлал хийх |
| | Хувьчлагдсан том үйлдвэрийн удирдлагыг бэхжүүлж, бүтцийг нь өөрчлөх | Үйлдвэрийн газрын бүтцийг өөрчлөн шинэчлэх |
| | ЗГББ-аар үйлчилгээ үзүүлэх замаар бизнесийн хөгжилд дэмжлэг үзүүлэх | Үйлдвэрийн газрын удирдлага, бүтцийг өөрчлөн шинэчлэх байгууллагыг дэмжих |
| | | Бизнесийн хөгжлийн байгууллагыг дэмжих |
| Төрийн захиргааны өөрчлөлт, шинэчлэлийн үр дагаврыг удирдаж зохицуулах | Өөрчлөлт, шинэчлэлийн сөрөг үр дагаврыг багасгах | -Хүн хүчийг зохицуулах бодлого боловсруулах |
| | | -Өөрчлөлтөд өртсөн хамт олонд туслах |
| | Төрийн албанд ажиллагчдын сонирхол, ёс суртахууныг сайжруулах | -Төрийн албаны ажлын цагийг хороодуулах |
| | | -Албан хаагчийн баталгааг сайжруулах |
| | | -Шагнал урамшлын нөлөөг дээшлүүлэх |

Өөрчлөлт, шинэчлэлийн үйл ажиллагааны 40 зорилт нь үйл ажиллагааны 20 гол зорилтыг, гол зорилт нь үйл ажиллагааны стратегийн 5 зорилтыг, стратегийн зорилт нь Засгийн газрын үйл ажиллагааны стратегийн эрхэм зорилтыг хэрэгжүүлэхэд тус тус чиглэж байгаа бөгөөд эдгээр нь Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны стратегийн өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах нэгдсэн бодлогыг багцлан тодорхойлж байна.

## Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮТЦИЙН ЕРӨНХИЙ ТОГТОЛЦООНЫ ӨӨРЧЛӨЛТ, ШИНЭЧЛЭЛИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО

**3.1.** Засгийн газрын үйл ажиллагааны чиглэлийн өөрчлөлт шинэчлэлийн талаар баримтлах нэгдсэн бодлогоос Засгийн газрын үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлого буюу Засгийн газрын өө хоорондоо өвөрмөц ялгаа бүхий 5 үндсэн салбар урган гарч байна Тухайлбал:

3.1.1. *Байгаль орчны салбар:* **Үүнд байгалийн нөөц баялаг (газар агаар, ус, ургамал, амьтан г.м.) багтана. Салбарын зорилго нь улс орны байгалийн нөөц баялгийн чанарыг алдагдуулахгүй байх, үр өгөөжийг ил дээд хэргээр нэмэгдүүлэхэд чиглэнэ.**

3.1.2. *Үйлдвэрлэлийн салбар:* **Үүнд хөдөө аж ахуй, аж үйлдвэр, уул уурхай багтана. Салбарын зорилго нь өсөлт, хөгжил, улс үндэстний сайн сайхан аж байдлыг хангахад чиглэнэ.**

3.1.3. *Дэд бүтцийн салбар:* **Үүнд эрчим хүч, нийтийн аж ахуйн үйлчилгээ, барилга, тээвэр, холбоо болон мэдээлэл багтана. Салбарын зорилго нь улс орны бие т үнэт зүйлсийг бий болгох, хөгжүүлэхэд чиглэнэ.**

3.1.4. *Нийгмийн салбар:* **Үүнд эрүүл мэнд, боловсрол, соёл, нийгмийн хангамж багтана. Салбарын зорилго нь хүн амын амьдралын чанарыг баяжуулан дээшлүүлэхэд оршино.**

3.1.5. *Бусад гол чиг үүргийн салбар:* **Үүнд хууль зүй, батлан хамгаалах, гадаад харилцаа хамаарна. Салбарын зорилго нь үндэсний эрхэмлэн дээдлэх зүйлсийг хадгалан хамгаалахад чиглэнэ.**

**3.2.** Засгийн газрын үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн загварыг дор дурдсан байдлаар тодорхойлов.


Төрийн захиргааны төв байгууллага
ҮНДЭСНИЙ БОДЛОГЫН ЗОРИЛГО
Удирдлагын ерөнхий чиг үүрэг
Байгаль орчны салбар
Үйлдвэрлэлийн салбар
Дэд бүтцийн салбар
Нийгмийн салбар
Бусад гол чиг үүргийн салбар
Чиглэлийн яам-стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах хөтөлбөр зохиох, зохицуулах, мониторингийн хяналт тавих, үнэлж дүгнэх чиг үүрэгтэй
Тохируулагч агентлаг-хууль тогтоомж, стандартыг сахиулах чиг үүрэгтэй
Хэрэгжүүлэгч агентлаг, төсөвт байгууллага-бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй
Нутгийн захиргааны байгууллага
ОРОН НУТГИЙН БОДЛОГЫН ЗОРИЛГО
Засаг даргын ажлын алба-стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, хөтөлбөр зохиох, зохицуулах мониторингийн хяналт тавих, үнэлж дүгнэх чиг үүрэгтэй
Хэрэгжүүлэгч агентлаг, төсөвт байгууллага-бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй
Хувийн хэвшил-Бодлогын зарим зорилгыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй
Засгийн газрын бус байгууллага-Бодлогын зарим зорилтыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй
Иргэд

Засгийн газар нь салбар тус бүрийн хүрээнд өөрийн үйл ажиллагаг доор дурдсан "чиг үүргийн хуваарь"-ийн дагуу зохион байгуулна:

3.2.1. Чиглэлийн яам нь **стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, хөтөлбөр зохиох, зохицуулах, мониторингийн хяналт тавих, үнэлж дүгнэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.**

3.2.2. Тохируулагч агентлаг нь **хууль тогтоомж, стандартыг албадан сахиулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.**

3.2.3. Хэрэгжүүлэгч агентлаг, төсөвт байгууллага нь **бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй ажиллана. Бодлогыг хэрэгжүүлэх чиг үүргийн заримыг төрийн өмчийн, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, эсхүл хувийн хэвшлийн буюу Засгийн газрын бус байгууллагад улсын төсвөөс санхүүжилт олгох замаар гүйцэтгүүлж болно.**

3.2.4. Нутгийн захиргааны байгууллага-бүх шатны Засаг даргын ажлын алба нь **засаг захиргаа, нутаг дэвсгэрийнхээ хүрээнд стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, хөтөлбөр зохиох, зохицуулах, мониторингийн хяналт тавих, үнэлж дүгнэх чиг үүргийг хэрэгжүүлнэ. Хэрэгжүүлэгч агентлаг, төсөвт байгууллага нь бодлогыг хэрэгжүүлнэ. Хувийн хэвшлийн буюу Засгийн газрын бус байгууллагаар бодлогын зарим зорилгыг хэрэгжүүлэх чиг үүргийг улсын төсвийн санхүүжилтээр гүйцэтгүүлж болно.**

**3.3** Удирдлагын ерөнхий чиг үүрэг (**үндэсний хөгжлийн төлөвлөлт макро эдийн засгийн шинжилгээ, санхүү, боловсон хүчин, гүйцэтгэх удирдлагыг дэмжих зэрэг**)-ийн байгууллага болон салбар дундын бусад чиг үүрэг (**худалдаа, хөдөлмөр, гааль, татварын зэрэг**)-ийг гүйцэтгэгдэг Засгийн газрын агентлаг нь чиглэлийн яамдын үйл ажиллагаанд туслалцаа үзүүлнэ.

Засгийн газар нь тэргүүлэн манлайлах чиг үүрэгтэй байх бөгөөд Ерөнхий сайд, Танхимын тэргүүлэн манлайлах чиг үүргийг дэмжих байгууллага нь Засгийн газрын ажлын алба болох Засгийн газрын Хэрэг эрхлэх газар байна.

Улсын болон хувийн хэвшил нь улс үндэстний хөгжил, дэвшил эдийн засгийн өсөлтийг хангах нэг гол хөдөлгүүрийн үүрэг гүйцэтгэнэ.

## Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ, БҮТЦИЙН ЕРӨНХИЙ ОГТОЛЦООНЫ ӨӨРЧЛӨЛТ, ШИНЭЧЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА, НӨӨЦИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО

**4.1.** Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхдээ доор дурдсан зарчмыг баримтлана:

4.1.1. Оновчтой хэмжээний зарчим: Монгол Улсын үндэсний хөгжилд үр нөлөөтэй бөгөөд аль болох компакт чадварлаг аппараттай төрийн захиргааны тогтолцоо бүй болгоно. Ингэснээр харьцангуй хөвөр үндэсний ажиллах хүч болон хөмс нөөцийг үйлдвэрлэлийн салбарт төвлөрүүлэх боломж бүрдэнэ.

4.1.2. Гүйцэтгэх дээд удирдлага үр нөлөөтэй тэргүүлэн манлайлагч байх зарчим: Төвөөс хүчтэй, харагдахуйц, үр нөлөө бүхий тэргүүлэн манлайлах үүргээ биелүүлж, төр, засгийн хэмжээнд тайлагнах нэгдсэн тогтолцоотой байж чадахаас өөрчлөлт, шинэчлэлийн ололт амжилт шалтгаална. Удирдлагын ерөнхий чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллагын үйл ажиллагааг сайжруулан нэгдмэл байдлыг хангаж, шилжилтийн үеийн үргэлжлэх хугацааг богиносгож, өртөг зардлыг багасгах болно.

4.1.3. Яамны удирдлага үр нөлөөтэй байх зарчим: Тэргүүлэн манлайлах явдал чиглэлийн яамдын түвшинд мөн хамаарна. Тэрчлэн энэ нь улсын болон хувийн хэвшил, төв, орон нутгийн түвшинд аль алинд нь хамаарах ба энэ утгаараа нийт улс орныг хамарсан шинжтэй байна. Төв, орон нутгийн түвшинд сайтар зохицуулсон бодлого, төлөвлөлтийн чиг үүргээр дамжиж тэргүүлэн манлайлах үүрэг биелэх боломжтой болно. Хувийн үйлдвэр, аж ахуйн газрыг төрийн өмчийн үйлдвэрийн газартай адил авч үзнэ. Ингэснээр хувийн хэвшил яамдыг өөрсдийн өрсөлдөгч буюу саад тотгор учруулагч биш, харин хөгжилд нь дэмжлэг үзүүлэгч гэж үздэг болно.

4.1.4. Оновчтой тохируулга хийх зарчим: Тохируулах чиг үүргийг хялбар байлгаж, тэдгээрийг аль болох цөөн тооны агентлагаар гүйцэтгүүлэх болно. Эдгээр агентлагийн гол зорилт нь улс үндэстний болон иргэд (ажилчид, хэрэглэгчид, хөрөнгө оруулагчид, агаарын хөлгөөр зорчигчид болон нийт хүн ам г.м.)-ийн ашиг сонирхол болон байгаль орчныг хамгаалахад оршино.

4.1.5. Үйлчилгээг оновчтой хүргэх зарчим: Тодорхой эрхэм зорилго бүхий хэрэгжүүлэгч агентлаг, төрийн захиргааны болон төсөвт байгууллагууд зорилгоо мэргэшлийн өндөр ур чадвартайгаар биелүүлэх болно. Харин тэдгээрийн удирдлага, санхүүжилт нь уян хатан байна. Тэд боломцооны хэрээр бие даан, өөрийгөө санхүүжүүлдэг байна. Удирдах зөвлөл маягийн хэлбэр нь удирдлагын бие даасан байдлыг хангах боломжийг бүрдүүлнэ. Санхүүгийн хувьд тэд улсын төсвөөс бүрэн, эсхүл хагас санхүүждэг байхаас гадна өөрийгөө бүрэн санхүүжүүлдэг байж болно. Нийгмийн шалтгаан буюу үндэсний аюулгүй байдлыг хангах үүднээс тэдгээр нь улсын төсвөөс санхүүждэг бол, энэ нь ил тод байхын зэрэгцээ санхүүжилтийн эх үүсвэрийг үйлчилгээ хүргүүлэх, эсхүл аж ахуйн үйл ажиллагаанаас урган гарсан бусад зардлыг санхүүжүүлэхэд зарцуулах бөгөөд харин түүнийг үр ашигтай захиргааны

зардалд хэрхэвч зориулж болохгүй. Шаардлагатай нөхцөлд эдгээр үйлдвэрийн газар нь хувийн хэвшилтэй өрсөлдөх бөгөөд хувийн хэвшлээс чанар сайтай үйлчилгээг хямд үнээр гэрээлэн авах боломжийг ашиглана. Өөрийгөө бүрэн санхүүжүүлж байгаа үйлдвэр аж ахуйн газрын ажил байдлыг үе үе судалж, төрийн өмчтэй үйлдвэр хэлбэрээрээ бүтцийн өөрчлөлт, шинэчлэл хийх, эсхүл хувьчлах эсэхийг шийдвэрлэж байх болно.

4.1.6. Хэрэглэгчдэд үйлчилгээг ойртуулах зарчим: Үйлчилгээг иргэдийн эрэлт хэрэгцээнд ойртуулж, төсвийн бэрхшээлтэй нөхцөлд аль болох хямд байлгахыг эрмэлзэнэ. Үйлчилгээ нь төвийн; аймаг, нийслэлийн; сум, дүүргийн; баг, хорооны гэсэн түвшинд хуваагдана. Орон нутгийн түвшинд үзүүлж буй үйлчилгээний чанарыг дээшлүүлэхийн тулд бүх шатны Засаг даргын ажлын албаны чадварыг дээшлүүлнэ.

4.1.7. Орон нутгийн удирдлага үр нөлөөтэй байх зарчим: Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжих тухай Үндсэн хуулийн заалтыг хэрэгжүүлэхийн тулд бүх шатны Хурлыг бэхжүүлэх, орон нутгийн хөгжлийн эдийн засаг, санхүүгийн бааз (орон нутгийн татвар, өмч)-ыг бий болгоно. Эдгээр асуудлыг шийдвэрлэснээр үйлчилгээ болон хөрөнгө оруулалтын тэргүүлэх чиглэлийг тогтоох, хөгжлийн төслийг хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоог өрнүүлэх нөхцөлийг бүрдүүлэх боломжтой болно. Орон нутагт ардчиллыг хөгжүүлэхэд бүх шатны Засаг даргын ажлын алба, Хурал болон орон нутгийн иргэдийн байгууллага хоорондын харилцаг улам боловсронгуй болгоно.

4.1.8. Улсын үйлдвэрийн газрын удирдлага үр нөлөөтэй байх зарчим: Бэлэн мөнгөний хувьчлал хийх, хувьчлалд үйлдвэр, аж ахуйн газрыг бэлтгэх, хувьчлалын гэрээг хуульд заасны дагуу байгуулан биелэлтэд нь хяналт тавих, үйлдвэрийн газрын бүтцийг өөрчлөн шинэчлэх, олонхи компанийн өмнө тулгарч байгаа удирдлагыг төгөлдөржүүлэх асуудлыг шийдвэрлэхэд дөхөм үзүүлэх, тэрчлэн үйлдвэрийн газрын удирдлагыг улам овсгоотой ажилладаг болгохын тулд улсын үйлдвэрийн газарт дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий тусгай агентлаг байгуулна.

4.1.9. Захиргааны нийтлэг үйлчилгээ үзүүлэх зарчим: Төрийн захиргааны нийтлэг үйлчилгээ (Засгийн газрын дотоод үйлчилгээ)-г төрийн захиргааны байгууллагын хүрээнд нэгдсэн журмаар зохион байгуулна. Ингэснээр өртөг зардал багасч, үйлчилгээний чанар үр дүн дээшилнэ. Захиргааны нийтлэг үйлчилгээний стандарт боловсруулан мөрдүүлэх бөгөөд энэ нь тодорхой стратегийн дагуу хөрөнгө оруулалт хийх, хөрөнгөө захиран зарцуулах, хомс хөрөнгө нөөцийг оновчтой зохицуулан хуваарилах боломж олгоно.

4.1.10. Хувийн хэвшил хөгжих таатай нөхцөл бүрдүүлэх зарчим: Хувийн хэвшил нь шударга өрсөлдөөний явцад өөрийгөө хөгжүүлэн үр нөлөөгөө дээшлүүлэх ёстой. Засгийн газар түүнд энэ боломжийг нь хангахуйц таатай орчныг бүрдүүлж өгөхөөс гадна түүний чадварыг дээшлүүлэх, хөрөнгийн эх үүсвэр олж өгөх замаар туслах болно. Засгийн газраас тогтоосон тэргүүлэх чиглэлийн дагуу гадаад хамтын ажиллагааны эх үүсвэрийн ихээхэн хэсгийг Монгол Улсад шаардлагатай удирдлагын чадварыг бий болгоход чиглүүлнэ. Энэ нөхцөлд хувийн хэвшлийг хөгжүүлэх, түүний чадварыг дээшлүүлэх үйлчилгээг Засгийн газрын дэмжлэгтэйгээр Засгийн газрын бус байгууллагуудаар дамжуулан үзүүлэх зохион байгуулалтын механизм бий болгоно. Засгийн газраас Засгийн газрын бус байгууллагад бодлогын зохих дэмжлэг үзүүлж, тэдгээрийн чадавхийг дээшлүүлэх үйл ажиллагааг гадаад хамтын ажиллагааны эх үүсвэрээс санхүүжүүлэн туслах болно.

**4.2.** Бодлогын баримт бичигт тусгагдсан төрийн захиргааны өөрчлөлт, шинэчлэлийн хамрах хүрээг дор дурдсан байдлаар тогтоож байна. Энэ хүрээг төрийн гүйцэтгэх дээд болон түүний харьяа холбогдох байгууллагуудаар хязгаарласан болно.

**Төрийн захиргааны өөрчлөлт, шинэчлэлийн хамрах хүрээ**

| Байгууллагын хүрээ | Үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээ |
|---|---|
| 1. Ерөнхий сайд, Танхим, Засгийн газрын ажлын алба | 1. Үндэсний хэмжээнд тэргүүлэн манлайлах, стратегийн удирдамжаар хангах |
| 2. Удирдлагын ерөнхий чиг үүргийн байгууллага | 2. Нэгдсэн бодлого ба төлөвлөлт |
| 3. Чиглэлийн яам | 3. Салбарын бодлого ба төлөвлөлт |
| 4. Тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг | 4. Тохируулах ба үйлчилгээ хүргэх |
| 5. Нутгийн захиргааны байгууллага | 5. Нутгийн захиргааны хэмжээнд тэргүүлэн манлайлах ба үйлчилгээ хүргэх |
| 6. Төрийн өмчийн үйлдвэр, аж ахуйн газар | 6. Бүтээгдэхүүн, үйлчилгээ, Засгийн газрын тэргүүлэх чиглэл |
| 7. Төрийн өмч давамгайлсан болон төрийн өмчийн оролцоотой хувьцаат компани | 7. Бүтээгдэхүүн, үйлчилгээ |
| 8. Удирдлагын хөгжлийн байгууллага | 8. Удирдлагын сургалт, зөвлөгөө |
| 9. Засгийн газрын бус бизнесийн хөгжлийн байгууллага | 9. Хувийн хэвшил Засгийн газрын дэмжлэгтэйгээр өөрөө хөгжих |

**4.3.** Зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн онцлог, төрийн ардчилсан бүтцэд тохирсон "удирдлагын арга барил"-ыг хэвшүүлэх нь Засгийн газрын эн тэргүүнд анхаарах асуудал мөн. Энэхүү арга барилын онцлог шинж нь дараах зүйлд оршино:

4.3.1. Эрх мэдлийг шилжүүлэх: эрх мэдлийг Улсын Их Хурлаас Засгийн газар (Ерөнхий сайд, Танхим)-т, Сайд нарт, шаардлагатай бол яам, агентлагын удирдлагад шилжүүлэх. Төрийн өмчийн үйлдвэр, аж ахуйн газарт эрх мэдлийг бие даасан байдлын хамт шилжүүлснээр тэдгээрт үр ашигтай ажиллах боломж олгоно.

4.3.2. Шийдвэр гаргах төвлөрлийг сааруулах: хэрэгжих хөтөлбөр, үзүүлэх үйлчилгээ нь хэрэглэгчид аль болох ойр, уян хатан байх, хэрэгцээг хангахуйц бөгөөд үр дүнтэй зохицуулагдсан байх.

4.3.3. Үр дүнд хүрэх: сайтар тодорхойлсон хөтөлбөрийг зорилт, хүрэх үр дүнд үндэслэн төлөвлөх, биелэлтийг нь хангах, дүгнэх.

4.3.4. Эрхэмлэн дээдлэх зүйлсийг ашиглах: үйлчилгээний чанарыг сайжруулах, намч бус байр сууринаас ёс зүйн хэм хэмжээний дагуу үйл ажиллагаа явуулах, төсвийн хөрөнгийг ухаалгаар зарцуулах.

4.3.5. Ил тод, хариуцлага хүлээх чадвартай байх: Засгийн газрын үйл ажиллагаа ард түмэнд нээлттэй, ил тод бөгөөд хэн юу хариуцаж байгаа нь тодорхой байх.

**4.4.** Зохион байгуулалтын шинэ соёл болох удирдлагын эрхэмлэн дээдлэх зүйлсийг нэвтрүүлнэ.

Засгийн газар тогтоол, шийдвэр, бусад заавар, журам (эсхүл хууль)-д бага найдаж, удирдах хүмүүсийн удирдах чадварт илүү түшиглэн ажиллах удирдлагын шинэ соёлыг нэвтрүүлнэ. Үүний тулд удирдах ажилтнуудад тодорхой хэмжээний эрх мэдэл олгох "захиргаадах, хянах" хэлбэрийн тогтолцоо, арга барилаас аль болох зайлсхийх болно. Удирдах ажилтнууд зөвхөн чадварлаг удирдах талаар өндөр хариуцлага хүлээхээс гадна Засгийн газрын нийт удирдлагыг үр нөлөөтэй байлгах нийтлэг хариуцлагыг мөн хуваалцана. Удирдлагын шинэ соёл нь удирдлагын эрхэмлэн дээдлэх зүйлсэд тусгалаа олох бөгөөд түүнийг Засгийн газрын байгууллага, төрийн албан хаагчид хэлбэрэлтгүй дагаж мөрдөнө.

Засгийн газар нь ард иргэдэд үзүүлэх үйлчилгээг тэргүүлэн манлайлах, хурдасгах үүрэг хүлээх бөгөөд харин уг үйлчилгээг бүй болгогчийн үүрэг хүлээхгүй. Удирдах ажилтан эргэж тайлагнадаг журмаар ажиллана. Засгийн газрын зохион байгуулалтын бүтцийн одоогийн нэгж бүр өөр өөрийн эрхэм зорилго, чиг үүргээрээ өөр хоорондоо зарим талаар ялгаатай байдаг хэдий боловч төрийн захиргааны өөрчлөлт, шинэчлэл хийх замаар Засгийн газрын "удирдлагын философи", удирдлагын эрхэмлэн дээдлэх зүйлсийг бататган хөгжүүлнэ. Удирдлагын эрхэмлэн дээдлэх зүйлс нь:

- хэрэглэгчдэд чиглэсэн үйлчилгээ (хэрэглэгчдийг тодорхойлж, тэдний хэрэгцээг хангасан байх)
- ажлын болон түншлэлийн сайн харилцаа, итгэл, хүндэтгэл тэргүүлэн манлайлал, алсын хараа
- хүчтэй, анхааралтай, шинийг санаачлагч, бүтээлч удирдлага
- үргэлж сайжруулан шинийг туршиж байх
- үнэнч байх, чин сэтгэлээсээ ажиллах, чанар, үр ашгийг эрхэмлэх
- өндөр мэргэшил, нэгдмэл байдал, үнэлгээ өгөх, шийдвэр гаргах болон төгс боловсронгуй болгох

**4.5.** Засгийн газрын үйл ажиллагааны стратегийн өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах нэгдсэн бодлого (эрхэм зорилго; стратегийн зорилт; гол зорилт; өөрчлөлт, шинэчлэлийн үйл ажиллагааны зорилт)-ыг удирдах, төлөвлөх, хэрэгжүүлэх үйл ажиллагааны дараалал, уг дараалалд тусгагдсан бодлогын зорилгыг хэрэгжүүлэх талаар өөр хооронд нь уялдуулан зохицуулсан арга хэмжээ, дэмжих тогтолцоо (төрийн захиргааны өөрчлөлт, шинэчлэлийн хөтөлбөр; ололт амжилтын үнэлгээ болон хэмжүүр; удирдлагын эрхэмлэн дээдлэх зүйлс; дагаж мөрдөх зарчмуудыг дэмжих)-г дор дурдсан байдлаар тодорхойлов:

Хугацааны зааг 10-15 жил — **ЭРХЭМ ЗОРИЛГО**

Хугацааны зааг 5 жил — **СТРАТЕГИЙН ЗОРИЛТ** *[бүгд=5]*

Хугацааны зааг 1-5 жил — ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГОЛ ЗОРИЛТ *[бүгд=20]*

ӨӨРЧЛӨЛТ, ШИНЭЧЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ
**(Төсөл/төслийн үр дүнгийн хэлбэрээр хэрэгжүүлнэ)**

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ӨӨРЧЛӨЛТ, ШИНЭЧЛЭЛИЙН ХӨТӨЛБӨР
**(Удирдлагын хөгжлийн хөтөлбөр)**
*УДИРДЛАГА БА ХЯНАЛТ*

ОЛОЛТ АМЖИЛТЫН ҮНЭЛГЭЭ БОЛОН ХЭМЖҮҮР
**(Эрхэм зорилго, стратегийн болон үйл ажиллагааны гол зорилт, өөрчлөлт, шинэчлэлийн үйл ажиллагааны зорилт)**

УДИРДЛАГЫН ЭРХЭМЛЭН ДЭЭДЛЭХ ЗҮЙЛС, БАРИМТЛАХ ЗАРЧМУУДЫГ ДЭМЖИХ

**4.6.** Төрийн захиргааны өөрчлөлт, шинэчлэл хийхэд үнэн хэрэгтээ Монголын нийгмийн бүх давхрага, бүлэг шууд болон шууд бус оролцох буюу хамрагдах болно. Гэхдээ Засгийн газрын тодорхой зарим байгууллага энэхүү өөрчлөлт, шинэчлэлийн гол түлхэх хүч болж, харин бусад давхарга, бүлэг болон байгууллага нь идэвхтэй хамрагдах юм.

Өөрчлөлт, шинэчлэлийг гардан удирдаж хэрэгжүүлэхэд Засгийн газрын дараах байгууллагууд оролцоно:

- **Ерөнхий сайд**
- **Танхим**
- **Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, удирдлагын ерөнхий чиг үүргийн бусад байгууллага**
- **Чиглэлийн яам**
- **Тохируулагч агентлаг**
- **Хэрэгжүүлэгч агентлаг болон төсөвт байгууллага**
- **Нутгийн захиргаа**
- **Улсын үйлдвэрийн газар, төрийн өмчийн оролцоотой хувьцаат компани**
- **Төрийн дэмжлэгтэй Засгийн газрын бус байгууллага**
- **Төрийн алба (төрийн албан хаагчид)**

Дор дурдсан байгууллага төрийн захиргааны өөрчлөлт, шинэчлэлд дэмжлэг үзүүлэх болно:

- **Улсын Их Хурал**
- **Ерөнхийлөгч**
- **Бүх шатны Хурал**

Төрийн захиргааны өөрчлөлт, шинэчлэлийг амжилттай хийж дуусгахын тулд дор дурдсан байгууллага, хүмүүсийн нөлөө, тусламж, дэмжлэг чухал үүрэг гүйцэтгэнэ.

- **Хувийн хэвшил**
- **Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид**
- **Хандивлагч орон, олон улсын байгууллага**
- **Хэвлэл, мэдээллийн байгууллага**
- **Улсын хэмжээний болон орон нутгийн иргэдийн зохион байгуулалттай хэсгүүд**
- **Гадаад, дотоодын сайн дурын байгууллагууд**

**4.7.** Төрийн захиргааны өөрчлөлт, шинэчлэлийн стратегийн зорилт, баримтлах зарчим, удирдлагын эрхэмлэн дээдлэх зүйлс нь бүх яам, тусгай газрын үйл ажиллагаа, бүтцэд өөрчлөлт ороход хүргэнэ. Энэхүү өөрчлөлт нь ардчилал, зах зээлийн харилцааны нөхцөлд Засгийн газрын үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэнэ. Цаашид шинэ аргаар хэрэгжүүлэх шаардлагатай болж байгаа Засгийн газрын чиг үүргийн үндсэн таван асуудлыг дор дурдвал:

- **Бодлогын үндсэн чиглэлийг тогтоох**
- **Бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах**
- **Тайлагнах**
- **Нөөцийн удирдлагаар хангах**
- **Гүйцэтгэх удирдлагаар хангах**

*4.7.1. Бодлогын үндсэн чиглэлийг тогтоох:* **Зах зээлийн нөхцөлд яамд төрийн үйл хэргийг удирдах эрхэм зорилгоо захиргаадалт, бодлогын хэрэгжилтэд хяналт тавих зэрэг шууд арга замаар бус, харин**

**стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах зэрэг шууд бус арга замаар хэрэгжүүлнэ. Үүний зэрэгцээ бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулж, мониторингийн хяналт тавьж, үнэлж дүгнэх ёстой. Үүнтэй холбогдуулан гүйцэтгэх тодорхой чиг үүргүүдийг дурдваас:**

- Стратегийн төлөвлөлт - **Улс үндэстний хэмжээний бодлогын зорилгыг тодорхойлох, тэдгээрийг хэрэгжүүлэх оновчтой бодлого, хөтөлбөрийг сонгох**
- Бодлогын удирдамжаар хангах - **Зах зээлийн нөхцөлд улс орны өмнө тулгарсан бодлогын зорилгыг хэрэгжүүлэхэд ард түмэн, байгууллагуудыг идэвхжүүлэх оновчтой хөшүүрэг** (дүрэм, горим, нөхөх төлбөр, тусламж, шагнал, урамшил зэрэг) **бий болгох**
- Хөтөлбөржүүлэх - **Бодлогын зорилгоо биелүүлэхэд чиглэсэн тодорхой ажиллагаа явуулах эрхийг Засгийн газрын байгууллагуудад олгох, түүнд шаардагдах хөрөнгө нөөцийг мэдэлд нь шилжүүлэх**
- Зохицуулах - **Бодлогыг хэрэгжүүлэхэд оролцож байгаа Засгийн газрын байгууллагуудын ажлыг нэгтгэн зохицуулахад гүс дөхөм үзүүлэх**
- Мониторингийн хяналт, үр дүнг үнэлж дүгнэх - **Бодлогын зорилгын ахиц дэвшил, бодлогын удирдамж, хөтөлбөрийн үйл ажиллагааны үр дагаврыг ажиглах**

Бодлогын үндсэн чиглэлийн хэрэгжилтийг хянах сайдын эрх мэдэл зах зээлийн нөхцөлд буурахгүй, зөвхөн энэ эрх мэдлийг хэрэгжүүлэх арга нь өөрчлөгдөнө. Яамд бодлого хэрэгжүүлэхэд шууд оролцохгүй бөгөөд энэ нь хэрэгжүүлэгч агентлаг бие даан идэвх санаачлагатай ажиллах нөхцлийг бүрдүүлнэ.

*4.7.2. Бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах:* **Засгийн газар нь бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах чиг үүргээ дор дурдсан аргаар биелүүлнэ:**

- **Үндэсний аюулгүй байдлыг хангах, Засгийн газрын үйл ажиллагаа болон ард түмний тусын тулд тогтоосон хууль тогтоомж, стандартыг мөрдүүлэхэд чиглэсэн албадан тохируулах чиг үүргийг удирдлагын орчин үеийн арга барил эзэмшсэн бие даасан, төрөлжсөн агентлаг гүйцэтгэх болно.**
- **Нийгмийн эрх тэгш байдал, бүс нутгийн хоорондын тэнцвэрийг хангах, эсхүл бусад бодлогын улмаас нийлүүлж байгаа бүтээгдэхүүн, үзүүлж байгаа үйлчилгээнд нөлөөлөх замаар нийм чиг үүргийг төсөвт байгууллага, төрийн өмчийн аж ахуйн нэгжээр дамжуулах буюу эсхүл хувийн хэвшлийн, Засгийн газрын бус байгууллагад санхүүжилт олгох замаар хэрэгжүүлнэ.**

Засгийн газар ийнхүү оролцохдоо ашиг олохын төлөө бус, харин бодлогоо хэрэгжүүлэхэд голлон анхаарах ёстой.

*4.7.3. Тайлагнах:* Хууль ёсыг сахихын тулд тайлагнах зарчимд ардчилсан төрийн бүтэц тулгуурладаг. Засгийн газрын үйл ажиллагааг ард түмэнтэй холбох холбоос нь төв болон орон нутгийн түвшинд томилогдсон төлөөлөгчид юм. Эдгээр төлөөлөгчид нь ард түмний эрэлт хэрэгцээ, санал хүсэлтэд Засгийн газар анхааралтай хандаж, хариу өгч байх баталгаа болно. Өнөөгийн нөхцөлд тайлагнах үндсэн чиг үүрэг нь:

- Орон нутгийн түвшинд Засгийн газрын үйл ажиллагаа болон улс төрийн эрх мэдлийн хоорондын холбоог бэхжүүлэх.
- Засгийн газрын бодлого, хөтөлбөр, зардлын үр дүнг тайлагнах ажиллагааг баталгаажуулах.

*4.7.4. Нөөцийн удирдлагаар хангах:* Засгийн газар бүхий л үйл ажиллагаандаа хөрөнгийг үр ашигтай зарцуулахад тэргүүн зэргийн ач холбогдол өгч байгаагаа үйл ажиллагааны ил тод байдал, тайлагнах ажлаараа нотлон харуулна. Нөөцийн удирдлагын үндсэн чиг үүрэгт анхаарал хандуулснаар дараах арга хэмжээг авна:

- Санхүүгийн удирдлага, хөндлөнгийн хяналтын чадавхийг сайжруулах
- Захиргааны нийтлэг үйлчилгээний чиг үүргийг нэгтгэн, боловсронгуй болгох
- Зардлыг аль болох хямдруулахын тулд байгууллагыг шинээр өөрчлөн байгуулах болон удирдлагын орчин үеийн бусад арга техникийг бүх яам, агентлагт нэвтрүүлэх
- Хувийн хэвшил, засгийн газрын бус байгууллага илүү үр ашигтай, үр нөлөөтэй гүйцэтгэж чадах үйлчилгээг Засгийн газрын байгууллага үзүүлэхээс татгалзах буюу тийм үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх

*4.7.5. Гүйцэтгэх удирдлагаар хангах:* Бодлогын зорилгод хүрэхийн улд Засгийн газрын анхаарлыг хандуулах асуудлын нэг нь гол үйл жиллагааг дахин инженерчлэх явдал юм. Гүйцэтгэх удирдлагын чиг үргийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд дараах зүйлийг хийнэ:

- Ерөнхий сайд, Танхим нь стратегийн ач холбогдол бүхий асуудалд анхааран ажиллах чадварыг бэхжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах
- Ажиллах сонирхолтой, чадварлаг албан хаагч бүхий цомхон төрийн захиргааны албыг төлөвшүүлэх

**4.8.** Хөгжингүй болон хөгжиж буй орны туршлагаас үзвэл, улсын эшлийн өөрчлөлт, шинэчлэлийг хэрэгжүүлэх арга нь бусад үндсэн үчин зүйлийн нэгэн адил тухайн өөрчлөлт, шинэчлэлийн зорилтыг ажилттай шийдвэрлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ. Монгол орны өвөрмөц онцлог, тус улсын төрийн захиргааны болон улс төрийн

орчин нөхцөлд тохирсон дор дурдсан аргыг сонгов:

*4.8.1. Шатлан хэрэгжүүлэх арга:* **Төрийн захиргааны өөрчлөлт, шинэчлэлийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Үе шат бүрийг Засгийн газрын бусад үндсэн асуудал, сонгуулийн хугацаа, нийгэм-эдийн засгийн ерөнхий байдал зэрэгтэй уялдуулан тогтоов. Ийнхүү шатлан хэрэгжүүлэх нь өөрчлөлт, шинэчлэлийн талаар байнгын эргэх холбоог хангахын зэрэгцээ тухайн нөхцөл байдлаас шалтгаалан төлөвлөгөөнд зохицуулалт хийх боломж олгоно.**

*4.8.2. Цаашид өсөн нэмэгдэх хандлагаар хэрэгжүүлэх арга.* **Өөрчлөлт, шинэчлэлийг цаашид улам бүр өсөн нэмэгдэх чиглэлээр хэрэгжүүлэхийн тулд хамгийн хялбар өөрчлөлтийг эхлэн хийх, дараа нь түүний амжилтад тулгуурлан дараагийн үе шатанд шилжих чиглэлийг баримтлана. Энэ аргын нэг үндсэн шинж нь өөрчлөлт, шинэчлэлийн арга хэмжээг тодорхой нутаг дэвсгэр, чиг үүргийн зарим хэсэг, эсхүл байгууллагын нэгжид турших явдал юм.**

*4.8.3. Үйл явцыг үнэлж дүгнэх арга:* **Өөрчлөлт, шинэчлэлийн үйл явцыг үнэлж дүгнэхдээ семинар, зөвлөлгөөнөөр хэлэлцүүлэх аргыг өргөн хэрэглэнэ.**

*4.8.4. Арга зүйг тухайн нөхцөлд тохируулан сонгож хэрэглэх арга* **Бүх өөрчлөлтийг бүгдийг нь нэгэн зэрэг иж бүрэн хэрэгжүүлэх нөөц боломж байхгүй нь ойлгомжтой. Иймд өөрчлөлтийг хэрэгжүүлэх тусгай арга зүйг сонгон авч, тухайн орчны хэрэгцээ шаардлагад тохируулан хэрэглэх болно. Чингэхдээ зөвхөн ганц нэг аргыг сонгохгүй, хэд хэдэн аргыг багц байдлаар сонгон авч хэрэглэх болно.**

*4.8.5. Аль болох энгийн хялбар байх арга:* **Өөрчлөлт, шинэчлэлийн төсөл, бие даасан үйл ажиллагааг зориуд нарийн түвэгтэй болгохгүй байхад анхаарна. Төрийн захиргааны өөрчлөлт, шинэчлэл хийх талаар гаргасан шийдвэр нь энгийн хялбар байх бөгөөд тодорхой зорилгод хүрэх үйл явцыг агуулсан байна.**

*4.8.6. Жолоогоо алдахгүй байх арга:* **Ганцхүү хэрэгжүүлэх боломжтой өөрчлөлт, шинэчлэлийн зорилтыг сонгон авах нь чухал. Нөөц боломжоос хэтэрсэн зүйлийг хийх гэсэн хандлага байдгийг анхаарч ажиллах болно. Ажлын ачаалал, нарийн түвэгтэй байдлыг тухайн байгууллагын давуу тал, ур чадварын түвшинтэй харьцуулан үзэж чадавхи доогуур байвал түүнийг дээшлүүлэх арга хэмжээ авах болно.**

*4.8.7. Эрх мэдэлтэй байх, тайлагнах, нөөцөө тооцох арга:* **Өөрчлөлт шинэчлэлийг хэрэгжүүлэх байгууллага нь тайлагнах тусгай журамтай тодорхой эрх мэдэлтэй, өөрийн гэсэн нөөц бололцоотой байх шаардлагатай. Хэрэв өөрчлөлт, шинэчлэлийг хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх мэдэл, нөөцөөр хангахгүй бол өөрчлөлтийг хэрэгжүүлэх талаар хариуцлага хүлээх боломжгүй болно гэдгийг анхааралдаа авна.**

**4.9.** Монгол Улсын төсөв, санхүүгийн өнөөгийн нөхцөлд төрийн ахиргааны өөрчлөлт, шинэчлэлийг төлөвлөж хэрэгжүүлэхэд хөрөнгийн ихээхэн **нөөц** шаардлагатай. Хандивлагч орон, олон улсын айгууллагын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн буюу эрэгжүүлж буй төслүүдийн зардал 11,5 сая ам. долларт хүрсэн өгөөд хандивлагчдын зөвшөөрлийг хүлээж байгаа төслүүдийн зардал 16,9 сая ам. доллар болно. Төрийн захиргааны өөрчлөлт, шинэчэлийг цаашид үе шаттайгаар хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эрэгцээг хандивлагч орон, олон улсын байгууллагад зохих журмын агуу тавьж, эх үүсвэр олох замаар санхүүжүүлэх болно.

**4.10.** Бодлогын баримт бичигт тусгагдсан бодлогыг хэрэгжүүлэх е шатыг дор дурдсан байдлаар тодорхойлж байна:

*4.10.1. I үе шат: Бодлого боловсруулах:* (Өөрчлөлт, шинэчлэлийн хлаар дэвшигдэж байгаа асуудлын шалтгааныг тогтоосны үндсэн эр уг асуудлыг шийдвэрлэх бодлого боловсруулах)

Хугацаа: 1995.07.01-1996.06.30

*4.10.2. II үе шат: Бодлогыг хэрэгжүүлж эхлэх:* (Бодлогын дагуу эрчлөлт, шинэчлэлийг хэсэгчилсэн байдлаар хийж эхэлнэ)

Хугацаа: 1996.07.01-1997.06.30

*4.10.3. III үе шат: Бодлогыг хэрэгжүүлэх*(Бодлогын дагуу эрчлөлт, шинэчлэлийг иж бүрэн хийнэ)

Хугацаа: 1997.07.01-1998.06.30

*4.10.4. IY үе шат: Бодлогыг хэрэгжүүлж дуусах:* (Бодлогыг рэгжүүлэх ажлын явц, үр дүнд үндэслэн өөрчлөлт, шинэчлэлийг нэгийрүүлэх арга хэмжээ авна)

Хугацаа: 1998.07.01-1999.06.30

*4.10.5. Y үе шат: Бодлогын шинэ хувилбар боловсруулах:* (Бодлогыг рэгжүүлсэн байдалд нэгдсэн үнэлгээ, дүгнэлт өгч шинээр вшигдэж байгаа асуудлын шалтгааныг тогтоосны үндсэн дээр длогын шинэ хувилбар боловсруулах)

Хугацаа: 1999.07.01-2000.06.30

Бодлогын баримт бичигт тусгагдсан төрийн захиргааны өөрчлөлт, инэчлэлийн үйл ажиллагаа таван жилийн хугацаанд хэрэгжинэ. нэ нь санал болгож буй өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд хангалттай цаг гацаа юм. Энэ нь цаашид өрнөн хөгжих үйл явц бөгөөд эрхэм рилгоо бүрэн биелүүлэхэд нилээд хугацаа шаардагдана. Гэхдээ гол рхшээлийг эхний таван жилд давен туулах болно.

**4.11.** Төрийн захиргаа, төрийн албаны өөрчлөлт, шинэчлэлийг лөвлөх, хэрэгжүүлэх явцад харгалзан үзвэл зохих зарим асуудлыг рдвал:

4.11.1 Аливаа сонгуулийн үр дүн нь бодлогын баримт бичигт **туссан** төрийн захиргааны өөрчлөлт, шинэчлэлд мэдэгдэхүйц **нөлөөлөл** үзүүлэхгүй.

4.11.2. **Өөрчлөлт, шинэчлэл нь улс төрийн хувьд** "төвийг сахисан" **шинж чанартай. Үйл ажиллагааны стратеги нь улс төрийн төлвөөс үл хамаарах бөгөөд тогтвортой байна.**

4.11.3. Хандивлагч **орнуудын** эгээс **хангалттай тусламж үргэлжлүүлэн үзүүлэх сонирхолтой байгаагаа илэрхийлж байгаа болно.** Энэ тусламж хамгийн үр дүнтэй салбарт чиглэх бөгөөд **тусламжийг** зохицуулж байх болно.

4.11.4. **Өөрчлөлт,** шинэчлэлийн **хөтөлбөрийг бүх түвшинд, тухайлбал, улс төрийн, төрийн захиргааны, олон нийтийн, олон улсын түвшинд ойлгож хүлээн авах урьдчилсан нөхцөл бий болсон.**

**4.12.** Төрийн захиргааны өөрчлөлт, шинэчлэлийг **хэрэгжүүлэх** стратеги, төлөвлөгөө боловсруулах, биелэлтийг нь зохион байгуулахдаа дор дурдсан хүчин зүйлийг харгалзан үзнэ:

*4.12.1. Хэрэгжүүлэх чин эрмэлзэл:* **Засгийн газрын удирдлага (Ерөнхий сайд, Танхим, сайд нар)-ын эгээс өөрчлөлт, шинэчлэлийг байнга, мэдэгдэхүйцээр дэмжиж, түүнийг хэрэгжүүлэх чин эрмэлзэлтэй** байна.

*4.12.2. Өөриймсөг хандах:* **Төрийн захиргаа, төрийн албаны бүх түвшинд энэ өөрчлөлт, шинэчлэл нь "Монголын өөрийнх нь өөрчлөлт" мөн гэсэн өөриймсөг ойлголт бий болсон.**

*4.12.3. Хэрэгжүүлэх боломжтой байх:* **Өөрчлөлт, шинэчлэлийг** хэрэгжүүлэх бүхий л зардлыг стратегийн ач холбогдол **бүхий хөрөнгө оруулалт** гэж үзнэ. **Өөрчлөлт,** шинэчлэлийн **төслүүд нь аль болох** хялбар, энгийн байх бөгөөд улс орны боломжоос хэтэрсэн, **нарийн** түвэгтэй аргаас аль болох зайлсхийнэ.

*4.12.4. Цаашид өсөн нэмэгдэх чиглэлээр хэрэгжүүлэх* ***чадвар:*** **Өөрчлөлт,** шинэчлэлийг шатлан, энгийнээс **эхэлж цаашид улам** гүнзгийрүүлэх чиглэлээр хэрэгжүүлнэ. Энэ нь **хүчин чадал, бололцоотой** **нөөцөд тулгуурлан үйл явцыг залж чиглүүлэх бололцоо олгоно.**

*4.12.5. Эрсдэл, хүсэн хүлээж байгаа үр дүн:* **Өөрчлөлт, шинэчлэл,** түүний хүлээгдэж байгаа үр дүн, эрсдэл **зэрэг хувьсагч хүчин зүйлсийн** харьцааг уялдуулан бодлогоор зохицуулна. Ингэснээр **шаардлага** тулгарсан үед зохицуулалт хийх, "гэнэтийн зүйл" аль болох **бага** тохиолдох баталгаатай болно.

4.12.6. *Практик шинж чанар:* **Өөрчлөлт, шинэчлэлийг хэрэгжүүлэх** бүхий л санаачилга нь ажил хэргийн шинжтэй, хэрэгжүүлэх **боломжтой** байх болно.

4.12.7. *Туршилтад тулгуурлах:* Өөрчлөлт, шинэчлэлийн гол арга хэмжээг сайтар боловсруулсан туршилтаас эхэлж хэрэгжүүлсний үндсэн дээр түүний амжилтад тулгуурлан хөгжүүлэх замаар шаталсан өргөтгөлжүүлнэ.

4.12.8. *Түншлэл:* Өөрчлөлт, шинэчлэл нь олон улсын зөвлөгч нараар хүч нэмэгдүүлсэн үндэсний мэргэжилтнүүдээс бүрдсэн багийн хүчээр, түншлэлийн замаар хэрэгжинэ.

## Тав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ, БҮТЦИЙН ЕРӨНХИЙ ТОГТОЛЦООНЫ ӨӨРЧЛӨЛТ, ШИНЭЧЛЭЛИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР ГАРАХ ҮР ДҮН

**5.1.** Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлж, төрийн захиргаа, төрийн албыг өөрчлөн шинэчилснээр доор дурдсан 6 чиглэлээр үр дүнд хүрнэ:



**5.2.** Төрийн захиргаа, төрийн албаны өөрчлөлт, шинэчлэлийн үр дүн нь ерөнхий агуулгаараа шилжилтийн үйл явцыг дэмжихэд чиглэгдэж байгаа бөгөөд энэ нь ардчилсан бүтэц, үйл явцыг дэмжих зах зээлийн эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах гэсэн хоёр гол чиглэлд хуваагдана.

Дээр дурдсан 6 чиглэлээр гарах ерөнхий үр дүн болон өөр хоорондоо харилцан уялдсан, хэмжиж болохуйц бөгөөд хүч сорьсон тодорхой үр дүнг дор дурдсан хүснэгтэд үзүүлэв:

| Ерөнхий үр дүн | Тодорхой үр дүн |
|---|---|
| **1. Ардчилал хөгжинө** | -Засгийн газрын үйл ажиллагаа ил тод болно.<br>-Засгийн газрын байгууллага, удирдлага нийтийн өмнө хариуцлага хүлээж, ажлаа тайлагнана<br>-Засаглалын үйл явцад олон нийтийг өргөн оролцуулна<br>-Мэдээллийн эрх чөлөө, мэдээлэл олж авах боломж бүрдэнэ |
| **2. Зах зээлийн эдийн засаг төлөвшинө** | -Хууль зүйн дэд бүтэц, зохицуулалтын хүрээ бий болно<br>-Засгийн газар үйлчилгээг хүргэгчийн үүргийг гүйцэтгэнэ<br>-Засгийн газар улсын үйлдвэрийн газраас үзүүлэг үйлчилгээнээс бусад үйлчилгээг хувьчлана<br>-Дотоод, гадаад худалдаа, хөрөнгө оруулалт өснө<br>-Бизнесийг дэмжих Засгийн газрын бус байгууллагатай хамтран ажиллана |
| **3. Засгийн газрын өртөг, зардал буурна** | -Давхардлыг арилгаж, үйлчилгээ хүргэх ажлыг боловсронгуй болгосноор үйл ажиллагааны зардлыг богино хугацаанд багасгана<br>-Засгийн газрын үр ашиггүй хөрөнгийг зарж борлуулна<br>-Нийтлэг үйлчилгээг сайжруулна<br>-Төрийн албан хаагчдын тоо цөөрнө |
| **4. Үр ашиг, үр нөлөө дээшилнэ** | -Мэдээллийн технологийг шинэчлэн, хэрэглэнэ<br>-Хэрэглэгчдэд үйлчлэх, үйлчилгээ үзүүлэх соёлыг нэвтрүүлнэ.<br>-Төвлөрлийг сааруулна, зохион байгуулалтын шинэчлэл хийнэ.<br>-Сургах, хөгжүүлэх ажилд ахиц гарч, ёс суртахууны түвшин дээшилнэ<br>-Удирдагчдад удирдах боломжоо олгох зарчимд суурилсан захиргааны бодлогын дэд бүтэц бий болгоно<br>-Гол хөтөлбөр, байгууллагыг бүтцийн хувьд шинэчлэнэ |

| | |
|---|---|
| 5. Тайлагнах, хянах ажил сайжруулах | -Төсөв, зардлын удирдлагын шинэ тогтолцоо бүрдэнэ<br>-Нягтлан бодох бүртгэл, хөндлөнгийн хяналтын шинэ тогтолцоо бий болно<br>-Эрх мэдлийг шилжүүлэх, тайлагнах ажил зүгшрэнэ<br>-Гүйцэтгэлийн хэмжүүр нэвтэрч, хөтөлбөрийн үнэлгээ бий болно<br>-Бүх гол ажлууд бизнес төлөвлөгөөтэй болно |
| 6. Засгийн газрын нэр хүнд дээшилж, итгэл олно | -Мэдээлэл солилцох, олон нийттэй харилцах ажил эрчимжинэ<br>-Засгийн газрын үүргийг дотоод, гадаад орчинд ижил ойлгодог болно<br>-Засгийн газар сайтар тодорхойлсон эрхэм зорилго, алсын хараатай ажиллана |

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1996 оны 5 дугаар сарын 28-ны өдөр — Дугаар 43 — Улаанбаатар хот

**Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай**

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай Монгол Улсын уулийн 25 дугаар зүйлийн 2-т заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Байгалийн бүс бүслүүрийн хэв шинжийг төлөөлж, шим андлын тэнцвэрийг хангах ач холбогдолтой, үзэсгэлэн төгөлдөр, өвөрмөц тогтоцтой, ховор амьтан, ургамлын байршил нутаг болох араах газар нутгийг дор дурдсан ангиллаар улсын тусгай амгаалалтад авсугай:

1/ Өмнөговь аймгийн Номгон, Баян-Овоо, Ханбогд, Дорноговь імгийн Хатанбулаг сумын өмнөд хэсгийн хилийн заагт орших орзонгийн говь, Зээмгэний говь, Хармагтайн говийг хамарсан ззар нутгийг "Говийн бага дархан цаазат газар";

2/ Баян-Өлгий аймгийн Цэнгэл, Улаанхус, Сагсай, Алтай сумын утаг дахь Монгол Алтайн нурууны Алтай таван богд уул, Өвчүү, лг уул, Хотон, Хурган, Даян нуурын орчмыг хамарсан газар утгийг "Алтай таван богдын байгалийн цогцолборт газар"; аянхонгор аймгийн Галуут, Эрдэнэцогт, Архангай аймгийн Булган, Іх тамир, Чулуут, Цэнхэр, Хотонт, Өвөрхангай аймгийн Бат-Өлзий,

Уянга, Хужирт, Хархорин сумын хилийн заяг нутаг дахь Гурван Анагийн нуруу, Хөх нуур, Эрхэт хайрхан, Суварга хайрхан, Орхоны эх, Улаанцуттлан орчмыг хамарсан газар нутгийг "Хангайн нурууны байгалийн цогцолборт газар";

3/ Дундговь аймгийн Өлзийт, Өмнөговь аймгийн Манлай, Дорноговь аймгийн Мандах сумын хилийн заагт орших Загийн усны хоолой, Модон овооны говийн хэсгийг хамарсан газар нутгийг "Загийн усны байгалийн нөөц газар"; Говь-Алтай аймгийн Бугат сумын нутаг дахь Монгол Алтайн нурууны дунд хэсэгт орших Алаг хайрхан уулын орчны газар нутгийг "Алаг хайрханы байгалийн нөөц газар"; Говь-Алтай аймгийн Цогт, Бигэр, Халиун сумын хилийн заагийн Монгол Алтайн нурууны төгсгөл хэсэгт орших Бурхан буудай уулын орчмыг "Бурхан буудайн байгалийн нөөц газар"; Дорноговь аймгийн Хатанбулаг сумын нутагт орших Эргэлийн зоо орчмын газар нутгийг "Эргэлийн зооны байгалийн нөөц газар"; мөн аймгийн Даланжаргалан, Айраг сумын нутгийн хилийн заагт орших Их Нарт, Хэцүү тээг орчмыг хамарсан газар нутгийг "Их нартын байгалийн нөөц газар";

4/ Дорноговь аймгийн Мандах сумын нутаг дахь Сүйхэнт уул орчмыг "Сүйхэнтийн дурсгалт газар" тус тус болгох.

2. Говийн бага дархан цаазат газрын хилийн заагийг 1 дүгээр хавсралтын ёсоор, Алтай таван богд, Хангайн нурууны байгалийн цогцолборт газрын хилийн заагийг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус батлаcугай.

3. Дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасугай:

1/ Загийн ус, Алаг хайрхан, Бурхан буудай уул, Эргэлийн зоо, Их нартын байгалийн нөөц газар, Сүйхэнтийн дурсгалт газрын хилийн заагийг тогтоох;

2/ шинээр улсын тусгай хамгаалалтад авсан газар нутаг дахь аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг 1996 оны III улиралд багтаан Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нийцүүлэн зохицуулах.

Дарга Н. БАГАБАНДИ

Монгол Улсын Их Хурлын 1996 оны
43 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

## ГОВИЙН БАГА ДАРХАН ЦААЗАТ ГАЗРЫН ХИЛИЙН ЗААГ

"А" хэсэг:

Өмнөговь аймгийн Номгон сумын нутаг дахь улсын хилийн 251 дүгээр багана Өнчийн овоо \1060,2\, түүнээс хойш орших 1155,5; 1180,5 тоотууд, 1180,5 тоотоос зүүн хойш орших 1207,5; 1199,1; 1217,3; 1265,3; 1294,2; 1301,7; 1365,1; 1323,5 тоотууд, 1323,5 тоотоос баруун хойш орших 1406,2 тоот, түүнээс хойш орших Сүүжийн улаан \1422,0\, түүнээс зүүн хойш орших Шивээ уул \1367,7\, Ханан хонгил \1149,0\, түүнээс баруун хойш орших 1133,8; 1192,1 тоотууд, түүнээс зүүн хойш орших 1202,2; 1327,9; 1360,7; 1660,8 тоотууд, 1660,8 тоотоос зүүн урагш орших Өнгөт овоо \1565,2\, Их уул \1528,2\, түүнээс зүүн хойш орших 1112,0; 1055,8; 1097,3 тоотууд, Улаан толгойн шандын худаг, Бага хавчиг уул \1239,6\, түүнээс зүүн урагш орших 1092,3; 1119,4 тоотоос зүүн хойш орших 1046,9; 1073,9 тоотууд, 1073,9 тоотоос зүүн тийш орших 1086,8 тоот, түүнээс зүүн хойш орших 1103,9; 1077,9 тоотууд, 1077,9 тоотоос урагш Баян-Овоо, Ханбогд сумын хилийн заагт орших Тогоо хар дэлийн овоо \1064,3\; 1033,6; 964,1 тоотууд, Бор овоо \965,0\, 967,6 тоот, Баян хар уул \937,6\; Хар тээг \869,6\, түүнээс урагш Таван худгийн агийн уул хүрч, түүнээс баруун тийш улсын хилийг дагасаар Өнчийн овоо \1060,2\-д орших 251 дүгээр багана.

"Б" хэсэг:

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дахь улсын хилийн 286 дугаар багана, түүнээс хойш орших 1136,9; 1014,0 тоотууд, 1014,0 тоотоос зүүн хойш орших 1049,6; 1046,5 тоотууд, Номгон уул \1161,0\, түүнээс зүүн хойш орших 996,8; 995,3; 1003,9; 997,3 тоотууд, 997,3 тоотоос зүүн хойш орших 960,0 тоот, түүнээс зүүн урагш орших 1532,0 тоот, түүнээс зүүн хойш орших Баруун хасар уул \1093,3\ түүнээс зүүн урагш 1010,1; 1034,4 тоотууд, 1034,4 тоотоос зүүн хойш орших 1046,3, 1065,8 тоотууд, 1065,8 тоотоос зүүн урагш 1066,0; 1091,0 тоотууд, 1091,0 тоотоос зүүн тийш орших 1136,4; 1170,4 тоотууд, 1170,4 тоотоос зүүн урагш орших 1059,7 тоот, түүнээс зүүн хойш орших Таван модны худаг, Тагтын худаг \1140,0\ түүнээс зүүн урагш орших Шар тойромын худаг, 1078,6 тоот, Харгалантын худаг, түүнээс урагш орших Шандын хяр \1170,9\, түүнээс баруун урагш орших Тотог толгой уул \1240,7\, түүнээс урагш орших 1216,3 тоот, түүнээс зүүн урагш орших Хянга уул

\1182,6\, түүнээс урагш орших Хар эрдэнэ уул \1219,8\, улсын хилийн 317-р багана, түүнээс баруун тийш улсын хилийг дагасаар улсын хилийн 286 дугаар багана.

Монгол Улсын Их Хурлын 1996 оны
43 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

## АЛТАЙ ТАВАН БОГД, ХАНГАЙН НУРУУНЫ БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН ХИЛИЙН ЗААГ

1. Алтай таван богдын байгалийн цогцолборт газар:

Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын нутаг дахь улсын хил дээрх 3530,2 тоот, түүнээс зүүн урагш орших 2449,3 тоот, түүнээс урагш орших 3327,9 тоот, түүнээс зүүн урагш орших 3170,0; 348382 тоотууд, Шивээт хайрхан \3349,7\, 3301,4; 2896,1; 2836,3; 2830,4; 3019,6; 2591,9 тоотууд, Хөх хүзүү уул \2724,5\, Баянзүрх уул \2635,9\, Ховд уул \2737,5\, 2432,4; 2691,9; 2763,8; 2630,1; 2536,1 тоотууд, 2536,1 тоотоос баруун урагш орших 2602,8; 2849,9 тоотууд, 2849,9 тоотоос зүүн урагш орших Цагаан асгатын өндөр \3430,4\, түүнээс баруун урагш орших 2631,9 тоот, түүнээс зүүн урагш орших 2761,2; 2822,7 тоотууд, 2822,7 тоотоос зүүн тийш орших 2809,4 тоот, түүнээс зүүн урагш орших 3160,5; 3387,9 тоотууд, 3387,9 тоотоос зүүн тийш орших 3128,7; 2972,4; 2679,9 тоотууд, 2679,9 тоотоос зүүн урагш орших 2597,3; 2611,9; 2364,7; 3011,1 тоотоос урагш орших Шарговь \3205,2\, 3184,1; 3129,4 тоотууд, 3129,4 тоотоос баруун урагш орших 3292,4 тоот, түүнээс зүүн урагш орших Шарговийн даваа, Баян-Өлгий аймгийн Алтай сумын нутаг дахь улсын хилийн Их даваа, түүнээс баруун тийш улсын хилийг дагасаар 3530,2 тоот.

2. Хангайн нурууны байгалийн цогцолборт газар:

Эгийн даваа \2588,0\, түүнээс зүүн хойш орших Доод, Дунд Ангархайн голын уулзвар, 2731,0 тоот, Тахидаг толгой \2478,0\, 2776,8 тоот, түүнээс хойш болон зүүн хойш ойн хормойгоор 1-10 тоот шонгууд, 10 тоот шонгоос зүүн хойш ойн хормойгоор Өгөөмөрийн амны голыг гаталж Хужиртын даваа, түүнээс зүүн тийш орших 2150,0 тоот, түүнээс зүүн урагш орших 2371,0 тоот, Шивэртийн гол, Хойт тамирын голын уулзвар, түүнээс баруун урагш орших Байшин овоо \2336,5\, 2662,7 тоот, түүнээс зүүн урагш орших 2822,4; 2691,0 тоотууд, Замтын гол, Мухар хужиртын голын уулзвар, Дунд телал уул \2752,7\, 3083,0 тоот түүнээс урагш орших 3293,8 тоот, түүнээс зүүн урагш орших Урд тамирын голын хойт, урд

салааны уулзвар, Доод хушт \3308,0\, 3105,0; 3144,0 тоотууд, 3144,0 тоотоос зүүн хойш орших 3310,0; 2827,0 тоотууд, Бурхан хайрхан уул \2884,0\, түүнээс хойш орших Зүүн хашлага уул \2710,0\, түүнээс зүүн хойш орших 2466,7 тоот, Шар булуу уулын зүүн тал \2464,0\, түүнээс зүүн тийш орших Гялаан уул \2422,2\, түүнээс зүүн урагш орших Манхан уул \2530,8\, 2235,7; 2252,7 тоотууд, 2252,7 тоотоос баруун урагш орших Цагаан асга \2495,0\, түүнээс зүүн урагш орших Могойн даваа, 2567,0; 2735,0; 2322,0; 2506,0 тоотууд, Тооройн өндөр \2650,3\, 2345,0 тоот, түүнээс зүүн тийш орших 2288,0; 2123,0 тоотоос зүүн хойш орших 2086,7; 2196,4 тоотууд, Ар гуя уул \1981,9\, Хүрэн толгойн уул \2325,3\, Өндөр овоот \2312,0\, түүнээс зүүн урагш орших 1956,5; 2050,0 тоотууд, 2050,0 тоотоос баруун хойш орших 1956,5; 2050,0 тоотууд, 2050,0 тоотоос баруун хойш орших 2364,0 тоот, түүнээс зүүн хойш орших Хутаг уул \2321,1\, Бакнзүрх уул \2252,4\, Нуурын гозгорын баруун даваа, түүнээс хойш орших 2070,3 тоот, Будлондон-Өвөр цагаан гүүтийн голын уулзвар, түүнээс зүүн тийш орших Их арцат, Бага арцатын голын уулзвар, түүнээс зүүн урагш орших Хангайн овоо \1953,4\, Өлийн хошуу, Өлийн хөтөл \1527,0\, Вангийн овоо 1813,1 тоот, түүнээс баруун урагш орших Ар модны овоо, түүнээс урагш орших 1955,9 тоот, түүнээс баруун урагш орших 1912,4; 1855,1 тоотууд, Бэрхийн даваа, Бэрх уул \1853,0\, Оорцог уул \1873,0\, 1787,4 тоот, Мухдаг уул \2010,7\, Цагаан гол, Өвтийн голын уулзвар, Өвтийн гол, Могойтын амны уулзвар, түүнээс зүүн урагш орших Могойтын рашаан, түүнээс зүүн тийш орших Хангайн цагаан чулуут, түүнээс баруун урагш орших Хангайн овоо \2674,0\, Хамрын даваа, Өвөр цэгээн \2799,7\, 2802,9 тоот, Ар цагаан \2967,0\, Шар булуу, Улаан даваа \2670,0\, Хитрууны даваа, 3126,0 тоот, Хүйсийн найман нуурын дурсгалт газрын хилийн заагийн 4 тоот шон, түүнээс баруун хойш эргэж Хүйсийн найман нуурын дурсгалт газрын хилийн заагийг даган тойрч 10 тоот шон, түүнээс баруун хойш орших Хөх даваа 3107,0; 3005,0 тоотууд, 3005,0 тоотоос баруун урагш орших Улиастай, Сүвийн голын уулзвар, түүнээс баруун хойш орших Тогоот манхан \2875,0\, түүнээс баруун урагш орших Сүвийн даваа \2665,0\, 3006,0 тоот, түүнээс урагш орших 3273,0 тоот, түүнээс баруун хойш орших Салхит уул \3233,0\, түүнээс баруун урагш орших Их асгат \3202,0\, 3062,0 тоот, Элбэхийн даваа \2816,0\, 3165,0; 3226,0; 3142,0 тоотууд, 3142,0 тоотоос баруун тийш орших Шар хөтөл, түүнээс хойш орших Эртөөнт голын эхний цохио, түүнээс барун хойш орших Дунд даваа \2797,0\, Индэрт уул \2902,0\, түүнээс хойш орших Цагаан хадны баруун өндөр, түүнээс баруун хойш орших Урд салааны уул \3527,0\, түүнээс хойш орших Дунд салааны уул \3446,0\, түүнээс зүүн хойш

орших 3507,0 тоот, түүнээс баруун хойш орших Зуслант уул \3085,0\, түүнээс баруун урагш орших Хүрдэтийн уул \3064,0\ түүнээс баруун тийш орших Хөх сайрын уул \3182,0\, түүнээс баруун тийш орших Хясаат уул \3364,0\, түүнээс баруун тийш орших 3227,0 тоот, түүнээс баруун урагш орших 3105,0; 3124,0 тоотууд 3124,0 тоотоос баруун хойш орших 3065,0 тоот, Ар мухар \2905,0\, түүнээс баруун тийш орших Дорнод хайрхан \2447,0\ 2801,0 тоот, түүнээс баруун хойш орших Цагаан туруутын гол Өлийн голын уулзварын 2067,0 тоот, Ёлтын зүүн хэц уул \2661,0\ 3243,0 тоот, Тогоо хайрхан \3306,0\, түүнээс зүүн хойш орших 3340,0 тоот, түүнээс баруун хойш орших Хан хавцгайт уул \3234,1\ түүнээс хойш орших Эгийн даваа \2588,0\.

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 1996 оны 3 дугаар сарын 30-ны өдөр | Дугаар 40 | Улаанбаатар хот |

**Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийн тухай**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг хавсралт ёсоор зөвшөөрсүгэй.

2. Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлагуудын үйл ажиллагааны стратеги, уг стратегид тохирсон цомхон чадварлаг бүтэц, орон тоо, төсвийг баталж мөрдүүлэх, ажлын нь үр нөлөөг дээшлүүлж төсөвт зардлыг нь бууруулах арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /М. Энхсайхан/-д даалгасугай.

**Дарга** **Р. ГОНЧИГДОРЖ**

Монгол Улсын Их Хурлын 1996
оны 40 дүгээр тогтоолын хавсралт

## ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДЫН ТОГТОЛЦОО, БҮТЦИЙН ЕРӨНХИЙ БҮДҮҮВЧ

| Эрхлэх асуудлын хүрээ, харьяалал | Засгийн газрын тохируулагч агентлаг | Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг |
|---|---|---|
| Ерөнхий сайдын харьяанд | 1. Тагнуулын төв газар<br>2. Төрийн өмчийн хороо | 1. Радио, телевизийн Хэрэг эрхлэх газар<br>2. Мэдээллийн "МОНЦАМЭ" агентлаг<br>3. "Засгийн газрын мэдээ" сонин<br>4. Газрын тосны Хэрэг эрхлэх газар |
| Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын харьяанд | | 5. Төрийн захиргаа, удирдлагын хөгжлийн институт<br>6. Төр, засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газар |
| Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд | 3. Татварын ерөнхий газар<br>4. Гаалийн ерөнхий газар<br>5. Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах алба<br>6. Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төв<br>7. Санхүүгийн улсын хяналт, шалгалтын газар | 7. Гадаадын хөрөнгө оруулалтын газар<br>8. Сорьцын улсын хяналтын алба |
| Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээнд | | |

| | | |
|---|---|---|
| Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээнд | 8. Цагдаагийн Ерөнхий газар | 9. Иргэний бүртгэл мэдээллийн улсын төв<br>10. Хорих байгууллагуудыг удирдах газар<br>11. Үндэсний архивын газар<br>12. Оюуны өмчийн газар<br>13. Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн газар |
| Байгаль орчны сайдын эрхлэх асуудлын хүрээнд | 9. Байгаль орчныг хамгаалах алба<br>10. Газар зохион байгуулалтын алба | 14. Ус, цаг уур, орчны шинжилгээний газар |
| Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээнд | 11. Зэвсэгт хүчний ерөнхий штаб<br>12. Хилийн цэргийг удирдах газар | 15. Иргэний хамгаалалтын газар<br>16. Гадаад харилцаа, мэдээлэл, судалгааны тусгай газар |
| Гэгээрлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд | 13. Боловсролын хяналтын алба<br>14. Соёлын өвийн төв | |
| Дэд бүтцийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд | 15. Дэд бүтцийн улсын хяналтын алба | 17. Нүүрсний газар<br>18. Эрчим хүчний удирдах газар<br>19. Зам барилгын газар<br>20. Авто тээврийн газар<br>21. Төмөр замын Хэрэг эрхлэх газар<br>22. Иргэний агаарын тээврийг удирдах газар<br>23. Шуудан, цахилгаан холбооны газар<br>24. Барилга, архитектурын газар |

| | | |
|---|---|---|
| | | 25.Нийтийн аж ахуй, үйлчилгээний газар<br>26.Улсын геодези, зураг зүйн газар<br>27.Аялал жуулчлалын үндэсний төв |
| Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд | 16.Худалдаа, үйлдвэрийг дэмжих алба<br>17.Мал аж ахуй, мал эмнэлгийн улсын хяналтын алба<br>18.Ургамал хамгаалал, газар тариалангийн улсын хяналтын алба<br>19.Геологи, уул уурхайн улсын хяналтын газар | 28.Улсын нөөцийн газар<br>29.Геологи, уул уурхайн газар<br>30.Мал аж ахуйн үржлийн газар<br>31.Мал эмнэлгийн удирдах газар<br>32.Хөдөө аж ахуй үйлдвэрийн санхүүгийн хяналтын алба |
| Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд | 20.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын алба<br>21.Хэрэглэгчдийн эрхийг хамгаалах алба<br>22.Эрүүл ахуй, халдвар нян судлалын үндэсний төв<br>23.Эм, биобэлдмэл, эмчилгээний чанарын улсын хяналтын алба | 33.Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар<br>34.Хөдөлмөр зохицуулалтын газар |

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1996 оны 9 дүгээр сарын 2-ны өдөр — Дугаар 42 — Улаанбаатар хот

**Түр хороо байгуулах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Ажлын байр бий болгох үндэсний хөтөлбөрийг боловсруулах түр хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

| | |
|---|---|
| Түр хорооны дарга | |
| 1. Ц. Энхтүвшин | -Улсын Их Хурлын гишүүн |
| Гишүүд: | |
| 2. Р. Амаржаргал | -Улсын Их Хурлын гишүүн |
| 3. Ши. Батбаяр | -Улсын Их Хурлын гишүүн |
| 4. Д. Баттулга | -Улсын Их Хурлын гишүүн |
| 5. Н. Баяртсайхан | -Улсын Их Хурлын гишүүн |
| 6. Л. Болд | -Улсын Их Хурлын гишүүн |
| 7. Да. Ганболд | -Улсын Их Хурлын гишүүн |
| 8. Г. Ганхуяг | -Улсын Их Хурлын гишүүн |
| 9. Ё. Гэрэлчулуун | -Улсын Их Хурлын гишүүн |
| 10. Р. Нарангэрэл | -Улсын Их Хурлын гишүүн |
| 11. Ү. Наранцэцэг | -Улсын Их Хурлын гишүүн |
| 12. Ж. Отгонбаяр | -Улсын Их Хурлын гишүүн |
| 13. Ч. Отгонбаяр | -Улсын Их Хурлын гишүүн |
| 14. Т. Очирхүү | -Улсын Их Хурлын гишүүн |
| 15. Ц. Төмөртогоо | -Улсын Их Хурлын гишүүн |
| 16. Д. Цогбадрах | -Улсын Их Хурлын гишүүн |
| 17. Х. Хулан | -Улсын Их Хурлын гишүүн |
| 18. Д. Энхтайван | -Улсын Их Хурлын гишүүн |
| 19. О. Энхтуяа | -Улсын Их Хурлын гишүүн |

2. Хөтөлбөрийг 1997 оны 1 дүгээр сарын 1-ний дотор боловсруулж Улсын Их Хуралд танилцуулахыг Түр хороо /Ц. Энхтүвшин/-нд даалгасугай.

**Дэд дарга** **Ц. ЭЛБЭГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 1996 оны 9 дүгээр сарын 3-ны өдөр | Дугаар 43 | Улаанбаатар хот |

**Застгийн газрын бонд гаргах тухай**

Үнэт цаасны тухай Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Бэлэн мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэхгүйгээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын сул чөлөөтэй мөнгөн хөрөнгийг эргэлтэд оруулж, үнэгүйдлээс хамгаалах, бэлэн мөнгөний нийлүүлэлтийг зохицуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор 15 хүртэл тэрбум төгрөгийн бонд гаргахыг Засгийн газар /М. Энхсайхан/-т зөвшөөрсүгэй.

2. Засгийн газрын бонд гаргах, арилжаалахтай холбогдсон журмыг боловсруулж, төсөв, санхүү, эдийн засгийн бодлогын байнгын хороонд танилцуулсны үндсэн дээр батлан мөрдүүлэхийг Засгийн газар (М. Энхсайхан), Монгол банк /Д. Моломжамц/-д даалгасугай.

**Дэд дарга** **Ц. ЭЛБЭГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1996 оны 9 дүгаар сарын 3-ны өдөр | Дугаар 45 | Улаанбаатар хот

**"Ардын эрх" сонины тухай**

"Ардын эрх" сонины зөвлөл дур мэдэн төрийн төв хэвлэлийн статусаас татгалзаж уг сонинг үндэсний бие даасан, өдөр тутмын чөлөөт хэвлэл болгон зарласан явдал хууль бус болохыг тэмдэглэж Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлын даргын 1996 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 23 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

2. Ц. Балдоржийг "Ардын эрх" сонины Ерөнхий эрхлэгчийн үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

3. "Ардын эрх" сонин түүний хэвлэх үйлдвэрийн хөрөнгө, санхүүгийн үйл ажиллагааг нарийвчлан шалгаж холбогдох арга хэмжээ авахыг Засгийн газар, Төрийн хянан шалгах хороонд даалгасугай.

4. Төрийн өмчийг хууль бусаар хувийн болгох ноцтой явдал гарч байгаад нухацтай дүгнэлт хийж, тэдгээрийг таслан зогсоох, цаашид гаргуулахгүй байхад чиглэсэн арга хэмжээ авч, төрийн өмчид тавих хяналтыг хүчтэй болгохыг Засгийн газарт үүрэг болгосугай.

5. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн байгуулалтын байнгын хороо /С. Зориг/-нд даалгасугай.

**Дэд дарга** **Ц. ЭЛБЭГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1996 оны 8 дугаар сарын 19-ний өдөр | Дугаар 181 | Улаанбаатар хот

**Г. Дамдинсүрэнг Зэвсэгт хүчний ерөнхий штабын даргаар томилох тухай**

Хошууч генерал Гомбосүрэнгийн Дамдинсүрэнг Монгол Улсын Зэвсэгт хүчний ерөнхий штабын даргаар томилсугай.

**Монгол Улсын Ерөнхийлөгч** **П. ОЧИРБАТ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1996 оны 8 дугаар сарын 20-ны өдөр | Дугаар 183 | Улаанбаатар хот

**Л. Жамбалжавт Монгол Улсын хүний гавьяат эмч цол олгох тухай**

Зэвсэгт хүчний клиникийн төв эмнэлгийн мэс заслын эмчээр 20 гаруй жил ажиллаж 9 мянга шахам мэс заслыг гардан хийж, манай улсын анагаах ухааны практикт лазерийн нягтруулсан туяагаар мэс засал хийх, идэвхжүүлсэн нүүрс болон амьтны дэлүүний тусламжтайгаар цусыг цэвэршүүлэх зэрэг аргыг бүтээлчээр нэвтрүүлэн олон арван хүний амийг аврахад оруулсан хувь нэмрийг нь үнэлж, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны анагаах ухаан, эмнэлгийн хөгжлийн газрын ерөнхий захирал Лхамсүрэнгийн Жамбалжавт Монгол Улсын хүний гавьяат эмч цол олгосугай.

**Монгол Улсын Ерөнхийлөгч** **П. ОЧИРБАТ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | |
|---|---|---|
| 1996 оны 8 дугаар сарын 28-ны өдөр | Дугаар 188 | Улаанбаатар хот |

**Баасангийн Дамчаад Монгол Улсын Хөдөлмөрийн баатар цол олгох тухай**

Барилгын салбарт он удаан жил үр бүтээлтэй ажиллаж, үйлдвэрлэлийн машин тоног төхөөрөмж угсрах арга технологийг гарамгай эзэмшиж Дарханы Цементийн завод, Цагаан тоосгоны болон Хар төмөрлөгийн үйлдвэр зэрэг 40 гаруй томоохон үйлдвэрийн тоног төхөөрөмж Ховд, Завхан, Дорноговь, Архангай, Говь-Алтай аймгийн төвлөрсөн халаалтын шугам сүлжээний угсралтын ажлыг чанартай гүйцэтгэж, хөдөлмөр хөнгөвчлөх, бүтээмж нэмэгдүүлэх, осол аюулгүй ажиллах нөхцөл бүрдүүлэхэд чиглэгдсэн олон багаж, хэрэгслийг санаачлан хийж үйлдвэрлэлд нэвтрүүлэн олон арван ажилчдыг өөрийн мэргэжилд дагалдуулан сургаж, бригадын хамт олноо чадварлаг удирдан тогтмол үр ашигтай ажиллуулан барилгын салбарыг хөгжүүлэхэд дорвитой хувь нэмэр оруулж байгааг нь үнэлж Барилгын цахилгаан сантехник угсралтын "Хүрд" компанийн бригадын дарга Баасангийн Дамчаад Монгол Улсын Хөдөлмөрийн баатар цол олгож, Сүхбаатарын одон, "Алтан соёмбо" тэмдгээр шагнасугай.

**Монгол Улсын Ерөнхийлөгч** **П. ОЧИРБАТ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | |
|---|---|---|
| 1996 оны 8 дугаар сарын 28-ний өдөр | Дугаар 189 | Улаанбаатар хот |

**Даншийн Санжид Монгол Улсын гавьяат барилгачин цол олгох тухай**

Барилгачин, бригадын дарга, дэмлаар үр бүтээлтэй ажиллаж, зочид буудал, соёл үйлчилгээний төв, орон сууцны олон арван барилгыг чанарын өндөр төвшинд барьж байгуулан ашиглалтад оруулж, хөдөлмөр хөнгөвчлөх, ажлын бүтээл нэмэгдүүлэхэд чиглэсэн

олон төрлийн багаж, тоноглол, төхөөрөмжийг санаачлан хийж үйлдвэрлэлд нэвтрүүлэн залуу ажилчдыг сургаж дадлагажуулахад идэвх зүтгэл гаргаж говь нутгийг барилгажуулах үйл хэрэгт оруулж байгаа гарамгай хувь нэмрийг нь үнэлж Өмнөговь аймгийн "Говь гурван сайхан" хувьцаат компанийн мастер, техникч Дашийн Санжид Монгол Улсын гавьяат барилгачин цол олгосугай.

**Монгол Улсын Ерөнхийлөгч** **П. ОЧИРБАТ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1996 оны 9 дүгээр сарын 7-ны өдөр — Дугаар 192 — Улаанбаатар хот

**Я. Пүрэвдоржид хошууч генерал цол олгох тухай**

Хилийн цэргийг удирдах газрын дарга Ядамдоржийн Пүрэвдоржид хошууч генерал цол олгосугай.

**Монгол Улсын Ерөнхийлөгч** **П. ОЧИРБАТ**

# МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ

1996 оны 7 дугаар сарын 17-ны өдөр — Дугаар 06 — Улаанбаатар хот

**Улсын Их Хурлын хуулийн 22 дугаар зүйлийн 1 дүгээр заалт Монгол Улсын Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 1 дүгээр заалтыг зөрчсөн тухай маргааны талаар**

Үндсэн хуулийн цэцийн энэхүү дүгнэлтийг 1996 оны 7 дугаар арын 17-ны өдрийн 15.30 цагаас хооронд Төрийн ордны 251 дүгээр рөөнд зөвлөлдөж гаргав.

Цэцийн хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Г. Совд даргалж, ишүүд Ж. Бямбаа /илтгэгч/, Н. Жанцан, С. Жанцан, Д. Чилхаажав арын бүрэлдэхүүнтэй, Цэцийн түшмэл Ж. Баттуяаг Цэцийн хуралааны нарийн бичгийн даргаар оролцуулан хийв.

Тус хуралдаанд маргагч тал болж нийслэлийн Баянгол дүүргийн 3 дугаар хорооны иргэн Д. Ламжав, Улсын Их Хурлын тгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Улсын Их Хурлын гишүүн С. Төмөр, '. Гончигдорж нар оролцов.

Иргэн Д. Ламжав 1996 оны 7 дугаар сарын 8-нд Үндсэн хуулийн эцэд хандаж гаргасан өргөдөлдөө: Улсын Их Хурлын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 1-ийн "Улсын Их Хурлын гишүүн Засгийн азрын гишүүнээр томилогдвол гишүүнийхээ бүрэн эрхийг хэвээр лдгална. Засгийн газрын бүрэлдэхүүнд байх Улсын Их Хурлын ишүүний тоо Засгийн газрын нийт гишүүний гуравны нэгээс этэрч болохгүй" гэсэн заалт нь Үндсэн хуулийн 29-ийн 1-ийг, хайлбал: Улсын Их Хурлын гишүүн нь хуулиар тогтоосон үүрэгт т хамаарах бусад ажил, албан тушаал хавсарч болохгүй гэсэн алтыг зөрчиж байна.

Өмнөх Засгийн газарт тохиолдсон энэхүү алдааг давтахгүй байх үднээс миний өргөдлийг Засгийн газрын шинэ Ерөнхий сайд, усад сайдыг томилогдохоос өмнө хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг эцээс гүнээ итгэмжлэн хүсч байна гэжээ.

Иргэн Д. Ламжав 1996 оны 7 дугаар сарын 9-ний өдөр цэцэд гсөн нэмэлт тайлбартаа:

1. ". . . Үндсэн хуулийн 20 дугаар зүйлд хууль тогтоох эрх эдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална, зүйл 25 дотор байгаа уль батлах, нэмэлт өөрчлөлт оруулах, хууль болон Улсын Их

Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах асуудлы Улсын Их Хурал өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ гэж заасан. Эдгээр заалтаар Улсын Их Хурлын, улмаар Улсын И Хурлын гишүүний үндсэн үүргийн зонхилох хэсэг тодорхойлогдож байгаа учраас Улсын Их Хурлын гишүүнтэй холбоотой аливаа хууль үндсэн үүргийн энэхүү зонхилох хэсэгт хохирол учруулах ёсгүй гэж үзэж байна. Гэтэл Улсын Их Хурлын гишүүнийг Ерөнхий сайд буюу Засгийн газрын гишүүн байхыг хуулиар зөвшөөрсөн нь тухайн гишүүнд хууль хэрэгжүүлэх, хууль тогтоох болон хуулийн хэрэг жилтийг хянах гэсэн хоорондоо сонирхлын зөрчил бүхий хоё үүргийг оногдуулж байна.

2. Практик талаасаа нэг хүн Засгийн газрын болон Улсын Их Хурлын гишүүний үүрэгт ажлыг давхар гүйцэтгэх боломжтой гэх үндэслэл бага бөгөөд энэ байдлыг хүлээн зөвшөөрсөн нь Улсын И Хурлын тухай хуулийн зүйл 22-ын 3 дотор байгаа "Улсын И Хурлын гишүүн Засгийн газрын бүрэлдэхүүнд орвол энэ хоёр албан тушаалын цалингийн аль нэгийг нь сонгох эрхтэй. Түүний ажлын цагийг зохицуулах журмыг Улсын Их Хурлын дарга Ерөнхий сайдтай зөвшилцөн захирамжаараа зохицуулна" гэсэн заалтаар нот логдож байна.

3. 1-д дурдсан сонирхлын зөрчил нь эрх мэдлийн хуваарилалта хохирол учруулж байгаагаараа ноцтой бөгөөд түүнийг Улсын И Хурлын тухай хуулийн зүйл 22-ын 2 дахь "Улсын Их Хурлы гишүүн Засгийн газрын бүрэлдэхүүнд орвол Улсын Их Хурлын болон бусад байнгын хорооны даргаар сонгогдож болохгүй бөгөө засгийн газарт итгэл хүлээлгэх, түүнийг огцруулах, өөрийг н Засгийн газрын гишүүнээр томилох зэрэг өөртэй нь шууд холбогдсон асууд-лаар санал хураахад таслах эрх эдлэхгүй" гэсэн заалтаар ч засах боломжгүй гэж үзэж байна.

4. Цэцээс миний өргөдлийг хууль зүйн үндэслэлтэй гэж дүгнэ тохиолдолд Улсын Их Хурлын тухай хуулийн зүйл 22-ын 2 ба 3 дах заалтуудыг нэгэн адил хамтад нь хүчингүй болгож өгөхийг гүнэ хүсье гэжээ.

Цэцийн хуралдаанд оролцож буй Улсын Их Хурлын итгэмж лэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн С. Төмөр хэлэхдээ:

Энэ асуудал бүр 1991 оны XII сард Монгол Улсын Үндсэн хуулийн төслийг хэлэлцэж байх үед яригдаж байсан. Ардын И Хурлын депутат Р. Хатанбаатар "Улсын Их Хурлын гишүүн Ерөнхий сайд болон зарим гол гол яамдын сайдаар хавсран ажиллаж болно" гэсэн санал гаргаж хэлэлцүүлжээ. Түүнийг нь депутатуудын олонх дэмжээгүй нь үнэн. Дараа нь депутат Болд, Дамдинсүрэн на "Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд хуулиар

тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй гэсэн томьёоллоор 2 дахин санал хураалгахад 82 хувиар төслийн томьёоллыг зөвшөөрсөн байна лээ. Хэдий тийм боловч Улсын Их Хурлын хуулийн 22-ын 1 дүгээр заалт Үндсэн хуулийн 29-ийн 1-ийг зөрчсөн гэж шууд үзэх үндэслэл муутай санагдана. Зөрчсөн, зөрчөөгүй гэж хэлэх хуулийн үндэслэл тодорхой биш учраас Үндсэн хуулийн цэц асуудлыг тал бүрээс нь нягтлан үзэж зөв шийдвэр гаргана гэж найдаж байна гэв.

Иргэн Д. Ламжав: Үндсэн хуулийн 20 дугаар зүйл, 25 дугаар зүйлийн нэгд заасан Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхийг Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын бүрэлдэхүүнд орсон ч бусад гишүүдтэйгээ хамт эдлэх учиртай. Тэгээд ч түүнд хязгаарлалт тавих хууль зүйн үндэслэлгүй санагдана. Засгийн газрын бүрэлдэхүүнд орсон Улсын Их Хурлын гишүүн хууль тогтоох, хуулийн хэрэгжилтийг хянах болон хууль хэрэгжүүлэх гэсэн нэгэн субъект хэрэгжүүлэхэд хоорондоо зөрчилд орж болзошгүй, эрх үүргийг нь эдлүүлэх нь Үндсэн хуулийн үзэл санаанд төдийлөн нийцэхгүй байна.

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Улсын Их Хурлын гишүүн Р. Гончигдорж Ардын Их Хурлын 12 дахь удаагийн сонгуулийн II чуулганаар Монгол Улсын Их цаазын төслийг хэлэлцэж байх үед 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсгээс Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн гэсэн үгийг хасаж шийдвэрлэсэн нь Улсын Их Хурлын гишүүн дээрх албан тушаалыг хавсран ажиллаж болохыг үгүйсгээгүй юм.

Улсын Их Хурлын гишүүн хууль тогтоох, гүйцэтгэх засаглалд хавсран ажиллаж байгаа нь засгийн эрх ард түмний мэдэлд байна гэсэн Үндсэн хуулийн заалттай нийцэж байна. Улсын Их Хурлын хуулийн 22 дугаар зүйлийн 1 дүгээр заалт нь Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 1-ийн агуулгад багтаж байгаа учраас энд Үндсэн хуулийн зөрчил гаразгүй гэж үзэх үндэстэй гэв.

Хянавал:

1. Улсын Их Хурал, түүний гишүүний үүргийг Монгол Улсын Үндсэн хуулийн 3 дугаар бүлгийн 20, 23, 25, 29 дүгээр зүйлүүдэд тодорхой заажээ.

2. Засгийн газрын гишүүний албан тушаал нь Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 1-д байгаа ". . . хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад ажил, албан тушаал" гэсэн ойлголтод хамаарахгүй болох нь хуралдааны явцад цугларсан нотлох баримтуудаар тогтоогдож байна.

3. Эдгээрээс үзэхэд Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн 29

дүгээр зүйлийн 1 дэх заалтыг зөрчиж байна гэсэн иргэн Д. Ламжавын гомдлыг хангах үндэслэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйл, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийг удирдлага болгон дүгнэлт гаргах нь:

1. Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсгийн:

1. Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүнээр томилогдвол гишүүнийхээ бүрэн эрхийг хэвээр хадгална. Засгийн газрын бүрэлдэхүүнд байх Улсын Их Хурлын гишүүдийн тоо Засгийн газрын нийт гишүүний гуравны нэгээс хэтэрч болохгүй.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурлын байнгын болон бусад хорооны даргаар сонгогдож болохгүй бөгөөд Засгийн газарт итгэл хүлээлгэх, түүнийг огцруулах өөрийг нь Засгийн газрын гишүүнээр томилох зэрэг өөртэй нь шууд холбогдсон асуудлаар санал хураахад таслах эрх эдлэхгүй.

3. Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын бүрэлдэхүүнд орвол энэ хоёр албан тушаалын цалин, хангамжийн аль нэгийг нь сонгох эрхтэй. Түүний ажлын цагийг зохицуулах журмыг Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдтай зөвшилцөн захирамжаарал тогтооно гэсэн заалтууд нь Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Улсын Их Хурлын гишүүн нь хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад ажил, албан тушаал хавсарч болохгүй" гэсэн заалтыг зөрчиж байна.

2. Энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногт багтаан хэлэлцэн хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

| | |
|---|---|
| Дарга | Г. СОВД |
| Гишүүд | Ж. БЯМБАА<br>Н. ЖАНЦАН<br>С. ЖАНЦАН<br>Д. ЧИЛХААЖАВ |

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 1996 оны 9 дүгээр сарын 9-ний өдөр | Дугаар 229 | Улаанбаатар хот |

**"Төв Ази" банкны талаар авах зарим арга хэмжээний тухай**

Улсын Их Хурлын Төсөв, санхүү, мөнгө, зээлийн болон Эдийн засгийн бодлогын байнгын хорооны чиглэлийг үндэслэн Сангийн яамнаас Монгол банктай тохиролцсоны дагуу нэг удаагийн арга хэмжээ болгон Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Шүүхээс "Төв Ази" банктай холбогдуулан авч хэрэгжүүлэх ажлын үр дүнд төвлөрөх мөнгөн хөрөнгөөс төлүүлэхээр тооцож, иргэдээс тус банкинд хадгалуулсан мөнгөн хадгаламжийн 1994 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдлээс 100,0 мянган төгрөг хүртэлх хадгаламжийг тэргүүн ээлжинд олгох, зарим иргэдийн хадгаламжийг бусад банкинд шилжүүлэх, валютын хадгаламжийг тухайн үеийн албан ханшаар тооцож төгрөгөөр олгох зэрэг арга хэмжээг Монгол банктай хамтран 1996 оны 12 дугаар сарын 1-ний дотор авч хэрэгжүүлэх, энэ арга хэмжээнд зориулж гэрээ байгуулах үндсэн дээр 500,0 хүртэл сая төгрөгийн зээлийн баталгаа Монгол банкинд гаргаж өгөхийг Сангийн яам (П.ЦАГААН)-д даалгасугай.

2. "Төв Ази" банк дампуурсантай холбогдуулан тус банкны хувь нийлүүлэгчид, удирдлага, ажилтнууд болон шүүхийн тогтоол, шийдвэрийг биелүүлээгүй зээлдэгчдэд хууль тогтоомжийн дагуу зохих хариуцлага хүлээлгэх талаар арга хэмжээ авч ажиллахыг Хууль зүйн яам (Ж.АМАРСАНАА)-д даалгасугай.

| | |
|---|---|
| Монгол Улсын Ерөнхий сайд | М.ЭНХСАЙХАН |
| Сангийн сайд | П.ЦАГААН |

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 1996 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр | Дугаар 236 | Улаанбаатар хот |

**Засгийн газрын мэдэлд хүнсний буудай худалдан авах тухай**

Газар тариалангийн аж ахуйн нэгжүүдэд ургац хураах үеийн болон гурилын үйлдвэрүүдэд хүнсний улаан буудай худалдан авах хөрөнгийн бололцоо хомсдож байгаатай холбогдуулан хүн амын гурилын хангамжийг тогтвортой байлгах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Намрын ургацаас борлуулагдахгүй үлдэх хүнсний буудайг Засгийн газрын мэдэлд худалдан авах, түүнийг хадгалах, борлуулах, санхүүжүүлэх журмыг боловсруулан батлаж мөрдөхийг Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд Л. Нямсамбуу, Сангийн сайд П. Цагаан нарт даалгасугай.

2. Хүнсний буудайг улсад худалдан авахад шаардагдах 2 тэрбум төгрөгийн хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэхийг Сангийн сайд П.Цагаанд үүрэг болгосугай.

3. Гурилын үйлдвэр, элеваторуудад хадгалах Засгийн газрын мэдлийн хүнсний буудайн хадгалалт, борлуулалт, улсын хөрөнгийн эргэн төлөлтөд хяналт тавьж ажиллахыг Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд Л.Нямсамбуу, холбогдох аймгийн Засаг дарга нарт даалгасугай.

| | |
|---|---|
| **Монгол Улсын Ерөнхий сайд** | М.ЭНХСАЙХАН |
| **Сангийн сайд** | П.ЦАГААН |
| **Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд** | Л.НЯМСАМБУУ |

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 1996 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр | Дугаар 237 | Улаанбаатар хот |

**Улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаар 1996 онд эхний ээлжинд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаар эхний ээлжинд барьж санхүүжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээг энэ тогтоолын 1, 2 дугаар хавсралт ёсоор тус тус шинэчлэн баталсугай.

2. Төвлөрсөн төсвийн эчааллаас шалтгаалан санхүүжилтийг түр зогсоож байгаа барилга байгууламжийн харуул хамгаалалттай холбогдсон зардлыг захиалагч, гүйцэтгэгч байгууллагууд албан ёсоор тохиролцож шийдвэрлэж байхаар тогтоосугай.

3. Улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтад өмч хувьчлалын сангаас төвлөрүүлэх хөрөнгийг нэмэгдүүлэх шуурхай арга хэмжээ авахыг Төрийн өмчийн хороо (З.ЭНХБОЛД)-д, төвлөрсөн хөрөнгийг дэд бүтцийн салбарын өөлжилтийн бэлтгэлийг хангах, ашиглалтад оруулах барилга байгууламжуудад тэргүүн ээлжинд хуваарилж санхүүжүүлэхийг Сангийн яам (П.ЦАГААН)-д тус тус даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг батлах тухай" Монгол Улсын Засгийн газрын 1996 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 15 дугаар тогтоолын 1, 2 дугаар хавсралтаас энэ тогтоолын 1, 2 дугаар хавсралтад заасан барилга байгууламж, төсөл арга хэмжээтэй холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

| | |
|---|---|
| **Монгол Улсын Ерөнхий сайд** | **М.ЭНХСАЙХАН** |
| **Сангийн сайд** | **П.ЦАГААН** |

Засгийн газрын 1996 оны 237 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

## УЛСЫН ТӨВЛӨРСӨН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР 1996 ОНД ТЭРГҮҮН ЭЭЛЖИНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

(сая төгрөг)

| № | Төсөл, барилга байгууламж, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил | Эхлэх,дуусах хугацаа | Санхүүжилтийн зохицуулсан хэмжээ | Захиалагч |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| | Бүгд | | 6061 | |
| | Нэг.<u>Төсвийн шууд хөрөнгө оруулалт</u> | | 5883 | |
| 1 | 110 кв-ын цахилгаан дамжуулах шугам, дэд өртөө: | | 2200 | |
| | -Баянмөнх-Өндөрхаан, 1x10 мВа, 88 км | 1995-1996 | 1260 | Дэд бүтцийн хөгжлийн яам |
| | -Өмнөговь сум-Өлгий хот, 2x16 мВа, 148,5 км | 1989-1996 | 100 | Дэд бүтцийн хөгжлийн яам |
| | -Өмнөговь сум-Мянгад сум -Ховд хот, 2 x 10 мВа, 137,1 км | 1993-1996 | 840 | Дэд бүтцийн хөгжлийн яам |
| 2 | 220 кв-ын цахилгаан дамжуулах шугам, дэд өртөөний дуусгал, Чойр-Мандалговь, 1 x 6,3 мВа, 177 км | 1996 | 50 | Дэд бүтцийн хөгжлийн яам |
| 3 | Цэвэр усны эх үүсгэврийн барилга: | | 395 | |
| | -Баянхонгор | 1992-1997 | 120 | Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газар |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| -Зуунмод | 1989-1996 | 15 | Төв аймгийн Засаг даргын Тамгын газар |
| -Улаангом | 1990-1997 | 50 | Увс аймгийн Засаг даргын Тамгын газар |
| -Дархан (резервуар) | 1989-1997 | 20 | Дархан-уул аймгийн Засаг даргын Тамгын газар |
| -Өмнөдийн цэвэр усны ф600 мм-ийн шугамаас баруун дүүргийн насосны станц хүргэлх ф400 мм-ийн шугам, Улаанбаатар | 1996 | 190 | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар |
| Цэвэрлэх байгууламж, бохир усны шугам: | | 171 | |
| -Даланзадгад (өргөтгөл) | 1993-1996 | 22 | Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газар |
| -Дархан (өргөтгөл) | 1985-1996 | 46 | Дархан-уул аймгийн Засаг даргын Тамгын газар |
| -Мөрөн | 1995-1997 | 50 | Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газар |
| -Арвайхээр | 1987-1996 | 13 | Өвөрхангай аймгийн Засаг |

| | 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|---|
| | | | | даргын Тамгын газар |
| | -"Их тэнгэр" цогцолбор | 1995-1996 | 40 | Төр, засгийн Үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газар |
| 5 | Халиаы хамгаалалт, Хялганат | 1996 | 30 | Булган аймгийн Засаг даргын Тамгын газар |
| 6 | Цэргийн байр, Ховд, 300 хүн | 1996 | 140 | Батлан хамгаалах яам |
| 7 | Орон сууц, Толгойт, 29 айл х 2 | 1989-1996 | 20 | Батлан хамгаалах яам |
| 8 | Цагдаагийн газрын барилга: | | 358 | Цагдаагийн ерөнхий газар, холбогдох аймгийн Засаг даргын Тамгын газар |
| | -Орон сууц, Өндөрхаан 24 айл | 1994-1996 | 32 | |
| | -4 машин бүхий галын депо, Өндөрхаан | 1989-1996 | 31 | |
| | -4 машин бүхий галын депо, Улаангом | 1992-1996 | 65 | |
| | -Мөрдөнгийн барилга, Даланзадгад | 1996 | 61 | |
| | -Цагдаагийн газрын байр, Замын-үүд | 1995-1996 | 169 | |

| | 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|---|
| 9 | Хил хамгаалалтын юриулалттай барилга: | | 281 | Хилийн цэргийг удирдах газар |
| | -Хилийн шалган нэвтрүүлэх байр, худаг, Завханы Нисэг | 1995-1996 | 8 | |
| | -12 дугаар хилийн хорооны халуун ус, бохирын шоног, инженерийн шугам сүлжээ, Дорноговийн Улаан-уул | 1995-1996 | 2 | |
| | -Цэргийн байр, орон сууц, агуулах, гарааш, халуун ус, Увсын Сагил | 1996-1997 | 43 | |
| | -Цэргийн байр, гарааш, халуун ус, агуулах, орон сууц, Увсын Шар-усүүр | 1996 | 49 | |
| | -Цэргийн байр, 3 машины гарааш, халуун ус, агуулах, моторын байр, Увсын Боршоо | 1996 | 30 | |
| | -Цэргийн байр, гарааш, халуун ус, агуулах, орон сууц, Увсын Тохой | 1996 | 44 | |
| | -Цэргийн байр, гарааш, халуун ус, агуулах, орон сууц, Увсын Хар цагаан ус | 1996 | 42 | |
| | -Орон сууц, гарааш, халуун ус, агуулах, контор, Завханы Зайгал | 1996 | 38 | |
| | -Цэргийн байр, Хэнтийн Дадал | 1996-1997 | 18 | |
| | -Тавтын пост, Сэлэнгэ | 1995-1996 | 5 | |
| | -Сумангийн барилгын дуусгал, Завханы Хачиг | 1995-1996 | 2 | |
| 10 | Авто тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх иогцолбор, Замын-үүд | 1995-1996 | 100 | Улсын гаалийн ерөнхий газар |

| 1 | | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|---|
| 11 | Хоригдлын ажлын байр бий болгох арга хэмжээ: | | 308 | Хорих байгууллагуудыг удирдах газар |
| | -Налайхын уурхайн С1-15 блокийг ашиглах бэлтгэл хангах | 1995-1996 | 40 | |
| | -Дамжин өнгөрүүлэх ангийн хоригдлын байр, Улаанбаатар (200 хүн) | 1996 | 6 | |
| | -Дотоодын цэргийн байр, Авдрант | 1996 | 20 | |
| | -Тоосгоны заводын дуусгал, Хэнтийн Өндөрхаан | 1996 | 8 | |
| | -Бусад | 1996 | 80 | |
| | -Гяндан, хугацаагүй хорих байр, Тахирсоёот, 120 хүн | 1996-1997 | 130 | |
| | -Ажлын байр шинээр бий болгох, Говьсүмбэр | 1996 | 24 | |
| 12 | Сургуулийн барилга: | | 506 | |
| | -Төвийн Баян-өнжүүл, 160 суудал | 1995-1996 | 82 | Төв аймгийн Засаг даргын Тамгын газар |
| | -Сэлэнгийн Хушаат, 320 суудал | 1993-1996 | 26 | Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газар |
| | -Говь-алтайн Тайшир, 320 суудал | 1989-1996 | 20 | Говь-алтай аймгийн Засаг даргын Тамгын газар |
| | -Хэнтийн Норовлин, 320 суудал | 1995-1996 | 38 | Хэнтий аймгийн |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | | | Засаг даргын Тамгын газар |
| -Хэнтийн Баян-адарга, 320 суудал | 1989-1996 | 34 | Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газар |
| -Ховдын Мөст, 240 суудал | 1990-1996 | 26 | Ховд аймгийн Засаг даргын Тамгын газар |
| -Өмнөговийн Даланзадгад, 320 суудал | 1990-1996 | 30 | Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газар |
| -Улаанбаатарын Баянхошуу, 928 суудал | 1991-1996 | 250 | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар |
| 3 Хүн эмнэлгийн барилга: | | 220 | |
| -Сүхбаатарын Онгон, 30 ор | 1990-1996 | 47 | Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газар |
| -Сүхбаатарын Наран, 15 ор | 1991-1996 | 43 | Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газар |
| -Төвийн Заамар, 15 ор | 1991-1996 | 40 | Төв аймгийн Засаг даргын Тамгын газар |

| | 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|---|
| | -Хэнтийн Жаргалтхаан, 15 ор | 1996-1997 | 25 | Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газар |
| | -Өвөрхангайн Хархорин, 90 ор | 1989-1996 | 15 | Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газар |
| | -Төрөх тасаг эохион байгуулах, Мандалговь, 30 ор | 1996 | 50 | Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газар |
| 14 | "Эрдэнэ зуу" хийдийн засвар, шинэчлэлт, Өвөрхангайн Хар-хорин | 1996-1998 | 50 | Гэгээрлийн яам |
| 15 | "Мэгжиджанрайсиг" бурханы цогцолбор, Улаанбаатар | 1994-1996 | 50 | Гэгээрлийн яам |
| 16 | Орон сууцны дуусгал, Зуунмод, 34 айл | 1996 | 9 | Төв аймгийн Засаг даргын Тамгын газар |
| 17 | Цэвэр усны шугамын дуусгал, Сайншанд | 1996 | 30 | Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газар |
| 18 | "Ханын материал" хувьцаат компанийн уурын зуух, Улаанбаатар | 1996 | 45 | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар |
| 19 | Угсрагдахгүй тоног төхөөрөмж | 1996 | 880 | |
| 20 | Засгийн газрын төсөл, хөтөлбөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж | | | Төр, засгийн Үйлчилгээ, аж |

| | 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|---|
| | байгаа төслүүдийн дотоод эх үүсвэр | 1996 | 40 | аҗуйг эрхлэх газар, Сангийн яам |
| | Хоёр. **Төсвийн зээл** | | 178 | |
| | Засгийн газрын төсөл, хөтөлбөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төслүүдийн дотоод эх үүсвэр | 1996 | 178 | Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яам |

Засгийн газрын 1996 оны 237 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

## УЛСЫН ТӨВЛӨРСӨН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТАД ТӨВЛӨРҮҮЛЭН ӨМЧ ХУВЬЧЛАЛЫН САНГААС ТЭРГҮҮН ЭЭЛЖИНД САНХҮҮЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

(сая төгрөг)

| № | Төсөл, барилга байгууламж, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил | Эхлэх, дуусах хугацаа | Санхүүжилтийн зохицуулсан хэмжээ | Захиалагч |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| | Бүгд | | 2661 | |
| | Нэг. **Өмч хувьчлалын сангийн шууд хөрөнгө оруулалт** | | 2131 | |
| 1 | 35 кв-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станц: | | 467 | |
| | -Тариалан, Булган, Хутаг-өндөрийн дэд станцын өргөтгөл, Хутаг-өндөр-Тариалангийн шугам | 1995-1996 | 127 | Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газар |

| | 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|---|
| | -Эрдэнэмандал-Цэцэрлэг, 40 км, 1 х 1 мВа | 1996 | 40 | Дэд бүтцийн хөгжлийн яам |
| | -Цагаандэлгэр-Говь-угтаал, 44 км, 1 х 1 мВа | 1996 | 143 | Дэд бүтцийн хөгжлийн яам |
| | -Тэвшийнговь-Дэлгэрцогт, 25 км, 1 х 1 мВа | 1996 | 156 | Дэд бүтцийн хөгжлийн яам |
| | -Өмнөговь сум-Өлгий сум, 19,4 км, 1 х 1 мВа | 1996 | 1 | Дэд бүтцийн хөгжлийн яам |
| 2 | 10 кв-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станц: | | 46 | |
| | -Сэлэнгийн Баруунбүрэн-Амарбаясгалант, 35 км, 1 х 0,4 мВа | 1996 | 35 | Дэд бүтцийн хөгжлийн яам |
| | -Заг-Гурванбулаг, 54 км, 2 х 0,16 мВа | 1996 | 11 | Дэд бүтцийн хөгжлийн яам |
| 3 | Усан цахилгаан станц, Ховдын Мянган, 100 квт | 1996-1997 | 16 | Ховд аймгийн Засаг даргын Тамгын газар |
| 4 | Төвлөрсөн уурын зуух, дулааны шугам, 40 Гкал/цаг, 2 х 3 км, Зуунмод | 1988-1996 | 50 | Дэд бүтцийн хөгжлийн яам |
| 5 | Тостоны уурын зуухны шинэчлэлт, Биокомбинат | 1995-1996 | 142 | Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яам |
| 6 | Дулааны цахилгаан станцын шинэчлэлт, Чойбалсан | 1995-1996 | 310 | Дэд бүтцийн хөгжлийн яам |
| 7 | III цахилгаан станцын шинэчлэлт, үнсэн сангийн байгууламжийн хамт, 3 | | | Дэд бүтцийн хөгжлийн яам |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| картт, 200 мян.$м^3$, Улаанбаатар | 1995-1997 | 200 | |
| Багануур хотын дулааны станцын элеваторын шинэчлэлт | 1996 | 67 | Дэд бүтцийн хөгжлийн яам |
| Багануур хотын дулааны станцын зуухыг буцламгай үед шилжүүлэх, Төмөргүй-жүүлэхээс дулааны станц хүргэх 4 км газарт цэвэр усны тэжээлийн шугам солих, 8 х 159,2 х 2/3, Багануур | 1996-1997 | 250 | Дэд бүтцийн хөгжлийн яам |
| Ахуйн үйлчилгээний төв, 350 хүнд, Шивээ-овоо | 1995-199- | 36 | Дэд бүтцийн хөгжлийн яам |
| Цэвэр усны эх үүсвэрийн барилга: | | | |
| -Амгалангийн фрейзерээс товчийн 3 хос шугам хүргэх ф 400 мм цэвэр усны шугамыг хос болгох, Улаанбаатар | 1996 | 180 | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар |
| Үр тарианы элеватор, Угтаал-цайдам, 36 мян.тн | 1988-1996 | 10 | Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яам |
| Нэгдсэн эмнэлэг, Арвайхээр, 120 ор | 1988-1998 | 110 | Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газар |
| Консулын байр, Улаан-үд | 1994-1996 | 100 | Гадаад харилцааны яам |
| Хэлмэгдэгсэд зориулан худалдан авах орон сууцны санхүүжилт, Улаанбаатар | 1996 | 50 | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар |

| 1 | | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|---|
| 16 | Түлш, эрчим хүчний үйлдвэрийн 1996-1997 оны өвөлжилтөд олгох санхүүжилт | 1996 | 97 | Дэд бүтцийн хөгжлийн яам |
| | Хоёр. **Өмч хувьчлалын сангаас эргэж төлөх нөхцөлөөр олгох** | | 530 | |
| 1 | Богдын голын 2000 кВт-ын усан цахилгаан станц, 35 кВт-ын цахилгаан дамжуулах шугам, дэд өртөө (Завхан) | 1993-1996 | 260 | Дэд бүтцийн хөгжлийн яам |
| 2 | Нарны эрчим хүчийг ашиглан хөдөөгийн жижиг хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангах, орон нутагт | 1996 | 30 | Дэд бүтцийн хөгжлийн яам |
| 3 | Цементийн үйлдвэр, жилд 10-15 мян.тн, Ховд | 1993-1996 | 170 | Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яам |
| 4 | "Бөхөг" компанийн шувууны аж ахуйн уураг зуух, сангасаар тэжээл бэлтгэх цех, Улаанбаатар | 1996 | 70 | Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яам |

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1996 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр — Дугаар 238 — Улаанбаатар хот

**Засгийн газрын комисс, Үндэсний зөвлөл, хороо, ажлын хэсгийн тухай**

Засгийн газрын бүтцэд өөрчлөлт орсонтой холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсаас гадаадын иргэдийн талаар баримтлах төрийн бодлогын хэрэгжилтэд хяналт тавьж, гадаадын иргэний эрх зүйн байдал, цагаачлалтай холбогдсон үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг бүхий Гадаадын иргэдийн асуудал эрхлэх зөвлөлийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтын ёсоор шинэчлэн баталсугай.

2. "Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохицуулах, хяналт тавих үүрэг бүхий Ядуурлыг бууруулах Үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралтын ёсоор шинэчлэн баталж, тус хорооны ажлын алба нь ядуурлыг бууруулах хөтөлбөрийн газар байхаар тогтоосугай.

3. Засгийн газрын гишүүдийн эрхлэх ажлын хүрээнд хамаарах Засгийн газрын комисс, Үндэсний зөвлөл, хороо, ажлын хэсэг (орон тооны бус) болон тэдгээрийн дарга нарыг 3 дугаар хавсралтын ёсоор баталж, холбогдох сайд, газар, байгууллагын дарга нартай тохиролцсоны үндсэн дээр бүрэлдэхүүнээ шинэчлэн тогтоож ажиллахыг дээрх комисс, Үндэсний зөвлөл, хороо, ажлын хэсгийн дарга нарт даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан 4 дүгээр хавсралтад дурдсан Сайд нарын Зөвлөл, Засгийн газрын тогтоол, тогтоолын заалт, хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

**Монгол Улсын Ерөнхий сайд** **М.ЭНХСАЙХАН**

**Хууль зүйн сайд** **Ж.АМАРСАНАА**

Засгийн газрын 1996 оны 238 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

## ГАДААДЫН ИРГЭДИЙН АСУУДАЛ ЭРХЛЭХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

| | |
|---|---|
| Зөвлөлийн дарга | Хууль зүйн сайд |
| Зөвлөлийн орлогч дарга | Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд |
| Гишүүд: | -Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга /Ерөнхийлөгчийн Тамгын газартай зөвшилцсөний үндсэн дээр/; |

| | |
|---|---|
| | -Гэгээрлийн яамны боловсролын газрын дарга; |
| | -Статистикийн газрын дэд дарга; |
| | -Татварын ерөнхий газрын дэд дарга;<br>-Тагнуулын төв газрын дэд дарга;<br>-Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн газрын дарга; |
| | -Хилийн цэргийг удирдах газрын штабын дарга; |
| | -Гаалийн ерөнхий газрын дэд дарга; |
| | -Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга; |
| | -Гадаад харилцааны яамны Консулын газрын дарга; |
| | -Сангийн яамны бүтцийн өөрчлөлтийн бодлогын газрын дарга; |
| | -Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яамны га даад худалдааны бодлого зохицуулалтын хэлтсийн дарга;<br>-Цагдаагийн ерөнхий газрын Иргэний бүртгэл мэдээллийн улсын төвийн дарга. |
| | -Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны харьяа гадаадад ажиллагчид гадаадын байгууллага, иргэдэд зуучла товчооны дарга. |
| Нарийн бичгийн дарга | -Орон тооны (яамны газрын даргатай адил эрхтэй) |

Засгийн газрын 1996 оны 238 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

## ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

| | |
|---|---|
| Дарга | -Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга |
| Гишүүд: | -Байгаль орчны яамны Төрийн нарийн бичгийн дарга;<br>-Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга;<br>-Гэгээрлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;<br>-Дэд бүтцийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;<br>-Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;<br>-Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн дарга;<br>-Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;<br>-Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга. |
| Нарийн бичгийн дарга | -Ядуурлыг бууруулах хөтөлбөрийн газрын захирал |

Засгийн газрын 1996 оны 238 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

## ЗАСГИЙН ГАЗРЫН КОМИСС, ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ, ХОРОО, АЖЛЫН ХЭСЭГ, ТЭДГЭЭРИЙН ДАРГА

| | |
|---|---|
| НҮБ-ын Хүнс тэжээл, хөдөө аж ахуйн нйгуулагын асуудал эрхэлсэн Монголын ндэсний комисс | Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд |

| | |
|---|---|
| 2. Д. Нацагдоржийн нэрэмжит шагнал эрхлэх комисс | Гэгээрлийн сайд |
| 3. Монголын түүх, соёлын дурсгалт зүйлийг эрэн сурвалжлах, хадгалан хамгаалах асуудлыг эрхлэх улсын комисс | Гэгээрлийн сайд |
| 4. Хилийн боомтын асуудал эрхэлсэн зөвлөл | Гадаад харилцааны сайд |
| 5. БНМАУ, ЗСБНХУ /хуучин нэрээр/-ийн хооронд үүссэн зээлийн өрийн асуудлыг зохицуулах талаар ОХУ-тай хэлэлцээ хийж, санал боловсруулах Монголын талын комисс | Сангийн сайд |
| 6. Үйлдвэрийн осол, байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, тэдгээрийн үр дагаврыг арилгах салбарт хамтран ажиллах Монгол-Оросын комиссын монголын хэсэг | Батлан хамгаалахын сайд |
| 7. Химийн хорт бодис ашиглах үйл ажиллагааг зохицуулах зөвлөл | Байгаль орчны сайд |
| 8. Цөмийн энергийн комисс | Гэгээрлийн сайд |
| 9. Монголын ховор амьтныг хамгаалах үндэсний комисс | Байгаль орчны сайд |
| 10. Улсын нэр томьёоны комисс | Гэгээрлийн сайд |
| 11. Олон улсын хөдөлмөрийн харилцааны хэм хэмжээний хэрэгжилтийг дэмжих үндэсний зөвлөлдөх хороо | Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд |
| 12. Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны чиглэлээр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үндэсний хороо /гурван талт/ | Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд |
| 13. Нийгмийн халамжийн Үндэсний зөвлөл | Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд |

| | |
|---|---|
| 14. Улсын ургацын комисс | Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд |
| 15. Дархлалын олдмол хомсдол өвчнөөс сэргийлэх, түүнтэй тэмцэх ажлыг зохицуулах үндэсний хороо | Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд |
| 16. НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага /ЮНЕСКО/-ын Монголын Үндэсний комисс | Гэгээрлийн сайд |
| 17. НҮБ-ын Үйлдвэр хөгжлийн байгууллага /ЮНИДО/-ын Монголын Үндэсний хороо | Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд |
| 18. Хувийн хэвшлийг дэмжиж хөгжүүлэх асуудлаар тэдгээрийг төлөөлөх байгууллагатай Засгийн газрын өмнөөс харилцаж ажиллах комисс | Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд |
| 19.Ази, Номхон далайн бүс нутгийн тахир дутуу хүмүүсийн 10 жилийн ажлыг Монгол Улсад эрхлэн зохион байгуулах үндэсний хороо | Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд |

Засгийн газрын 1996 оны 238 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт

## ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ЗАСГИЙН ГАЗАР (САЙД НАРЫН ЗӨВЛӨЛ)-ЫН ТОГТООЛ,ТОГТООЛЫН ЗААЛТ, ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

1. "Үндэсний комисс байгуулах тухай" 1974 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн 318 дугаар тогтоолын 2 дугаар зүйл.
2. "Комиссын бүрэлдэхүүнийг батлах тухай" 1991 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн 115 дугаар тогтоол.
3. "Д.Нацагдоржийн нэрэмжит шагнал эрхлэх комиссын бүрэлдэхүүн, уг шагналыг олгох журмын тухай" 1993 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 14 дүгээр тогтоолын 3 дугаар зүйл.
4. "Улсын комисс байгуулах тухай" 1993 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 147 дугаар тогтоолын 1 дүгээр зүйл.

5. "Дани улсын буцалтгүй тусламжийг ашиглах талаар авах зарим арга хэмжээний тухай" 1993 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 169 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйл.

6. "Засгийн газар хоорондын комиссын Монголын хэсэг болон бусад комисс, хорооны тухай" 1994 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 66 дугаар тогтоол.

7. "Комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай" 1994 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 77 дугаар тогтоол.

8. "Хилийн мэргэжлийн хяналтыг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" 1994 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 78 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт.

9. "Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 1994 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 104 дүгээр тогтоолын хавсралт.

10. "Зөвлөл байгуулах тухай" 1994 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 107 дугаар тогтоолын 1 дүгээр зүйл.

11. "Хөдөөгийн нийгмийн асуудал эрхэлсэн хороо байгуулах тухай" 1994 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 118 дугаар тогтоол.

12. "Комиссыг өөрчлөн байгуулах тухай" 1994 оны 10 дугаа сарын 12 -ны өдрийн 176 дугаар тогтоолын 1 дүгээр зүйл.

13. "Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай" 1994 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 230 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн "Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагааг зохицуулж шуурхай удирдлагаар хангах үүрэг бүхий удирдлагын нэгжийг Хүн амын бодлого,хөдөлмөрийн сайдын дэргэд ... " гэсэн хэсэг.

14. "Тогтоолын хавсралтыг шинэчлэн батлах тухай" 1995 оны дүгээр сарын 12-ны өдрийн 50 дугаар тогтоол.

15. "Комиссын Монголын хэсгийн бүрэлдэхүүнийг батлах тухай" 1995 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 71 дүгээр тогтоол.

16. "Зөвлөлийн бүрэлдэхүүнийг тогтоож, дүрмийг батлах тухай" 1995 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн 155 дугаар тогтоолын 1 дүгээр зүйл.

17. "Цөмийн энергийн комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай" 1995 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 185 дугаар тогтоол.

18. "Улсын нэр томьёоны комиссын бүрэлдэхүүн, дүрмийг шинэчлэн батлах тухай" 1995 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийі 216 дугаар тогтоолын 1 дүгээр зүйл.

19. "Хөтөлбөр хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай" 1995 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 223 дугаар тогтоолын 1 дүгээр зүйл.

20. "Хяналтын хорооны бүрэлдэхүүнд нэмэлт оруулах тухай" 1995 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 226 дугаар тогтоол.

21. "Үндэсний хөтөлбөр, зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай" 1996 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 8 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт.

22. "Үндэсний зөвлөлдөх хороо байгуулах тухай" 1996 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн 18 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт.

23. "Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 1996 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн 19 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйл.

24. "Нийгмийн халамжийн үндэсний зөвлөл байгуулах тухай" 1996 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн 41 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг.

25. "Үндэсний хорооны бүрэлдэхүүний тухай" Засгийн газрын 1996 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 105 дугаар тогтоол.

26. "Монгол Улсын Ерөнхий сайд, шадар сайд нарын голлон рхлэх удирдлага, зохицуулалт, хяналтын болон зөвлөх асуудлын уваарийг батлах тухай" 1993 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 112 угаар тогтоол.

## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ

| | | |
|---|---|---|
| 1996 оны 5 дугаар сарын 29-ний өдөр | Дугаар 153 | Улаанбаатар хот |

**Төрийн албаны тухай хуулийн зарим зүйлийн заалтыг тайлбарлах тухай**

Төрийн албаны тухай Монгол Улсын хуулийн зарим зүйлийн заалтыг нэг мөр ойлгон зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Үнд сэн хуулийн 50 дугаар зүйлийн нэг дэх хэсэг, Шүүхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийг удирдлага болгон Монгол Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

Төрийн албаны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн · дүгээр заалт, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дугаар заалты доор дурдсанаар тайлбарласугай:

1. Төрийн албаны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дүгээр заалтын "Төрийн өмчийн үйлдвэрийн газрын захиргаанı албан тушаал" гэдэгт төрийн өмчийн буюу төрийн өмчийн орол цоотой үйлдвэрийн газарт Төрийн болон орон нутгийн өмчийı тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1, 5 дахь хэсэг, Нөхөрлөл, компа нийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дугаар заалт 85 дугаар зүйлийн дагуу томилогдсон захирал, гүйцэтгэх захира Төрийн өмчийн хороо буюу эрх бүхий бусад байгууллагаас тогтоо сон захиргааны албан тушаал хамаарна.

2. Энэ тогтоолын 1-р зүйлд заасан төрийн өмчийн үйлдвэрийı газрын захиргааны албан тушаалд Нөхөрлөл компанийн тухаı хуулийн дагуу өөрчлөн зохион байгуулахаас өмнө үйл ажиллагаага явуулж байсан улсын үйлдвэрийн газарт Аж ахуйн нэгжийн тухаı хуулийн 42 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 5 дахь хэсгийн 3 дугаа заалтын дагуу томилогдсон дарга, захиргааны гишүүд, түүнчлэн Өм хувьчлах тухай хуулийн дагуу хувьчлагдахаас өмнө үйл ажиллагаага явуулж байсан улсын үйлдвэрийн газрын захиргааны гишүүдийı албан тушаал нэгэн адил хамаарна.

3. Иргэний хуулийн 75 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг, 87 дугаа зүйлийн 1 дэх хэсэг, 143, 144 дүгээр зүйл, Нөхөрлөл, компаниı тухай хуулийн 85 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Төрийн өмчийı оролцоотой компаний хувьд төрийн өмчийн оролцоотой хувь тэн цүүлэн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, хянан шалгагчий төрийн эрх бүх байгууллагаас томилох эрх олгохоор дүрэмд заана гэж; Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээ

үйлийн 5 дахь хэсэгт "Төрийн өмчийн төлөөлөгч нь энэ хуулийн 0 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан агентлагийн өөрийн төлөөөгч, эсхүл өөр байгууллагад ажиллаж байгаа төрийн захиргааны олон үйлчилгээний албан хаагч байна" гэж тус тус тодорхойлсон, өрөөр хэлбэл энэ хуульд Төрийн албаны хуулиас өөрөөр заасан тул 'өрийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 угаар заалтын "хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол хувь нийүүлсэн аж ахуйн нэгжийг гардан удирдах, тэдгээрийн нэгдлийн дирдах зөвлөлийн болон захиргааны гишүүн байх"-ыг хориглосон аалт нь төрийн өмчийн буюу төрийн өмчийн оролцоотой бүх эрлийн аж ахуйн нэгжид хамаарахгүй.

4. Төрийн албаны тухай хуулийн энэ зүйл, хэсэг, заалтын "хувь ийлүүлсэн гэдэг"-т эд хөрөнгө, хөдөлмөрөө хоршиж нэгтгэсэн бүх эрлийн нөхөрлөл, компани, хоршоо, үйлдвэрийн газар, түүний этор гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийг хамааруулан ілгоно.

Ерөнхий шүүгч Д. ДЭМБЭРЭЛЦЭРЭН

Шүүгч Д. ДАНЗАНДОРЖ
Б. ЦОГНЯМ

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

| | |
|---|---|
| Ерөнхий эрхлэгч | Л. Цог |
| Нарийн бичгийн дарга | **Сан. Жаргалсайхан** |
| Гишүүд | Б. Цэндоо |
| | Ч. Бавуу |
| | Б. Ганбат |
| | Б. Янжинлхам |
| Техник редактор | С. Итгэлт |
| Уншиж хянасан | **Сан. Жаргалсайхан** |
| | Б. Янжинлхам |

Үйлдвэрт шилжүүлсэн 1996 оны 11-р сарын 27-нд Өрөлтөд 1996 оны 11-р сарын 28-нд. Хэвлэлтэд 1996 оны 12-р сарын 19-нд. Хэвлэлийн хуудас 6,25. Хэвлэсэн тоо 4200.

**Манай хаяг:** Улаанбаатар-12
Төрийн ордон. Утас 322838

**Төр, засгийн Үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын харьяа хэвлэх үйлдвэр**